



GaVaL.net



Б. БАТЖАВ

# БИЕ ХАМГААЛАХ ТАКТИК



Улаанбаатар  
2005 он

Чухал хэргийн мөрдөн байцаагчаар ажиллаж  
байгаад 26 насандаа хорвоог орхисон  
хайрт ээж Базаргүрнийн БАЛЖНЯМ -даа  
зориулав.

БАТСАЙХАНЫ БАТЖАВ

~~Батсайханы Батжав~~

Батсайханы Батжав

2005.07.22

Батсайханы Батжав

Батсайханы Батжав 2005

22/07

ХЯНАСАН:

Д. АДЪЯАБАЗАР

хууль зүйн ухааны доктор, Дэд профессор

ШҮҮМЖ БИЧСЭН:

Н. ГАНТУЛГА

хууль зүйн ухааны доктор /Ph/

О. САМБУУ

хууль зүйн ухааны магистр

ХЭВЛЭЛИЙН ЭХИЙГ:

БАЕРС ХХК

ЗУРГИЙГ:

Б. БОЛОРЦЭЦЭГ

ЗОХИОГЧИЙН ЭРХ © 2005

ЗОХИОГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ХЭВЛЭЖ ОЛШРУУЛАХЫГ ХОРИГЛОНО!

## ӨМНӨХ ҮГ

Хүн үүсч бий болсон цагаасаа өнөөг хүртэл өөрийн мэдсэн зүйлийн хязгаарыг даван гарахыг ямагт хүсэн эрмэлзэж аливааг үргэлж сайжруулан шинэчлэхийг тэмүүлжирсэн билээ.

Дэлхий нийтэд терроризмын аюул заналхийлэл нүүрлэсэн өнөө үед Монгол орон тайван замаар хөгжиж байгаа ч улс орон, төр засгийн тогтворгүй байдал, нам, эвсэл хөдөлгөөний хямрал, гадны шашны урсгалууд дэлгэрч байгаа нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист үйл ажиллагаа гарахгүй гэх баталгаа байхгүй байна.

Ийм цаг үед цагдаагийн болон хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын агуулга бүтэцэд шинэчлэлт хийх зайлшгүй шаардлага гарч байна.

Иймд миний бие өөрийн амьдралын 19 жилийг дорно дахины гардан тулааны олон төрлийн урлагууд болон зэвсгийн эрдмийг судалж, суралцаж, зааж ирсэн туршлага, Цагдаагийн байгууллагад 15 жил ажиллаж боловсорсон мэдлэг чадвар дээрээ тулгуурлан "Албаны бэлтгэл", "Албаны тусгай бэлтгэл", "Самбо каратэ" зэрэг олон нэр хэрэглэн заагдаж байгаа хичээлийг нэг нэр томъёонд оруулж сургалтын агуулга бүтцийг өөрчлөн шинэчлэх зорилгоор "Бие Хамгаалах Тактик" хэмээх нэрийг гаргасан. Энэ бүтээлдээ ойлголт, агуулга бүтцийг нь тодорхой тайлбарласан болно.

"Бие хамгаалах тактик" хичээл нь бие бялдар, сэтгэл зүйн хөгжлийг хөгжүүлэх хэрэглүүр болоод зогсохгүй хүчний байгууллагуудын алба хаагчдын эзэмшвэл зохих албаны сургалт болно.

Бие хамгаалах тактикийн нэр томъёо, агуулга, бүтцийг гаргахдаа БНХАУ, Израил, ОХУ -ын цэрэг, цагдаагийн сургалт, Түрк улсын Цагдаагийн Академийн энэ төрлийн хичээл сургалтыг судалж өөрийн орны цагдаагийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулан гаргалаа.

Энэхүү бүтээлийг энхийг сахиулагч цэрэг цагдаагийн болон харуул хамгаалалтын тусгай албадын, албаны бэлэн байдлыг хангахад болон сургалтанд зориулж анх удаа сурах бичгийн хэмжээнд бичиж байгаа тул уншин судлагч өргөн олон өөрсдийн үнэтэй санал зөвлөгөөгөө Цагдаагийн байгууллагын албаны ба авто бэлтгэлийн тэнхимийн хаягаар бичиж ирүүлнэ гэдэгт итгэж байна.

Уншигч Таны билгийн мэлмий нээгдэж, тулааны урлагийн ухаанд шимтэн суралцаж, эрүүл энх байхын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Зохиогч Б. БАТЖАВ

## ӨМНӨХ ҮГ

### ГАРЧИГ

Хуудас

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БИЕ ХАМГААЛАХ УРЛАГ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН

ТҮҮХЭН ТОВЧОО \_\_\_\_\_ 1-3

- Кунгфу
- Каратэ
- Айкидо
- Байлдааны самбо
- Жудо
- Жиу жи цу
- Монгол бөх
- Монгол зоо

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

БИЕ ХАМГААЛАХ ТАКТИКИЙН ОЙЛГОЛТ, АГУУЛГА, БҮТЭЦ\_ 4-8

- Албаны бэлтгэл
- Бие хамгаалах тактикийн ойлголт
- Бие хамгаалах тактик хичээлийн агуулга бүтэц
- Мэх хэрэглэх эрх зүйн зохицуулалт

### ГУРАВДУГААР БҮЛЭГ

БИЕ ХАМГААЛАХ ТАКТИК \_\_\_\_\_

9-13

- Дасгалын эхний шат
- Бие халаалт
- Суллалтын дасгалууд
- Амьсгалын дасгалууд

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНДСЭН ТЕХНИК \_\_\_\_\_

14-28

- Зогсолтын техник
- Өнхрөлт, уналт
- Гарын цохилтын техник
- Гарын хамгаалалтын техник
- Хөлийн өшиглөлтүүд
- Хийсвэр тулаан

**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**ХАМГААЛАХ, НЯЦААЛТ ӨГӨХ АРГУУД** \_\_\_\_\_ **29-32**

- Гарын цохилтыг хамгаалах нь
- Хөлийн өшиглөлтөөс хамгаалах нь
- Барьцнаас чөлөөлөх аргууд
- Боох аргууд
- Баривчлах аргууд

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**  
**ЗЭВСЭГТЭЙ ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ АРГУУД** \_\_\_\_\_ **33-36**

- Хутгатай довтолгооноос хамгаалах
  - Дээрээс хутгатай довтолох үед
  - Чичиж довтолох үед
  - Доороос довтолох үед
- Буутай довтолгооноос хамгаалах
  - Урдаас буу тулгасан үед
  - Араас буу тулгасан үед
- Биед үзлэх хийх, хүлэг хийх аргууд

**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТАКТИК** \_\_\_\_\_ **37-40**

- Резин бороохойгоор хамгаалах, довтолох аргууд
- Гав хэрэглэх арга

**НАЙМДУГААР БҮЛЭГ**  
**НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫГ ТАСЛАН**  
**ЗОГСООХ ТАКТИК** \_\_\_\_\_ **41-69**

- Багийн тактикийн зохион байгуулалт
- Бүлгийн тактикийн зохион байгуулалт
- Салааны тактикийн зохион байгуулалт

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**  
**ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ** \_\_\_\_\_ **70-78**

- Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж
- Зүрх зогсох үед үзүүлэх анхны тусламж
- Шархтанд үзүүлэх анхны тусламж
- Үений мултралт, ясны хугаралтанд үзүүлэх анхны тусламж

**НОМ ЗҮЙ** \_\_\_\_\_ **79**

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



БИЕ ХАМГААЛАХ УРЛАГ  
ҮҮСЭЖ ХӨГЖСӨН НЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### БИЕ ХАМГААЛАХ УРЛАГ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН ТҮҮХЭН ТОВЧ

Хүн төрөлхтөн түүхэн хөгжлийнхөө явцад олон шинэ зүйл бүтээсний нэг нь хүн өөрийн бие махбодыг зэвсэг болгон араатан амьтан дайсан этгээдээс өөрийгөө болон овог аймгаа хамгаалж ирсэн түүхтэй бөгөөд нийгмийн хөгжлийн явцад урлаг спорт болон өргөжин хөгжиж улам боловсронгуй болсоор иржээ. Тухайлбал: Таэквондо, бокс, жудо гэх мэт тулааны урлаг нь олимпын төрөл болж дэлхийн өнцөг булан бүрт хөгжин цэцэглэж байна. Эдгээр нь улс орон болгонд өөрийн үндэсний хэв маяг, зан заншлыг шингээсэн өөрийн гэсэн нарийн дэг журам, философитойгоор хөгжиж ирсэн байна. Өнөөдөр дэлхий дээр 1500 - гаад төрлийн гардан тулааны урсгал чиглэлүүд байгаагийн зарим нэгнээс товч танилцуулъя.

#### КУНГ ФУ /Хятад бокс/<sup>1</sup>

МЭӨ I зуунд Квай -Мо гэдэг хүн кунфу -гийн анхны стилийг зохиож "урт сарвууны мэх" гэж нэрлэсэн байна. III зуунд эмч Хуа -То нь бар, могой сармагчин, тогоруу, буга зэрэг тулааны шинэ арга мэхийг боловсруулсан ба дараа нь могой, харх, морь, луу зэрэг арга мэхийг нэмж оруулсан. VI зуунд Шао -Линь сүмд "Боди -Дхарма" хэмээгдэгч Уа Ма Ли Та Ма гэгч энэтхэг гаралтай, буддизмыг номлогч нь тулааны урлагийг цогц урлаг болгож түүний бясалгалыг гүнзгий мэдэхэд бие сэтгэлээ зориулж бүтээл туурвисан. Кунфу олон зууны эрэл хайгуулаар үүссэн олон урсгал чиглэлийг холбож өгсөн нийлмэл төгс төгөлдөр бясалгалын гүн ухааны шинжтэй тулааны урлаг юм. Тиймээс зарим стиль нь гоёмсог бүжиг санагдуулж байхад мөн каратэ -г санагдуулсан огцом хөдөлгөөн, хүчтэй цохилттой ч байдаг. XV зуунд хятад бокс /кунгфу/ Японы Окинава арал руу шилжин дэлгэрсэн байна.

#### КАРАТЭ /Хоосон гар/

Каратэ нь Японы Окинава арлаас үүсэлтэй бөгөөд үндэслэгч нь Гичин Фунакоши /карат -г анх спорт болгон хөгжүүлсэн/ Шотокан төрлийг үндэслэгч юм. Каратэ нь өөрийн хөгжлийн явцад олон чиглэлээр хөгжиж ирсэн бөгөөд каратэ -гийн хөгжилд Гичин Фунакоши -гийн шавь нар маш их үүрэг гүйцэтгэсэн. Түүний шавь нарын зохиосон каратэ -гийн төрлөөс Шодуни Кёнва /Вадо -рю төрлийг үндэслэгч/, Мосутацу Ояма /Киокушин каратэ -г үндэслэгч/, Хидуки Ашихара /Ашихара каратэ -г үндэслэгч/ зэрэг хүмүүсийг дурьдаж болно. Миний уншиж судласнаар Японы каратэ -гийн 25 төрөл дэлхий дээр хөгжиж байна.

<sup>1</sup> Д. Отгонбаяр "Монгол зоо", 2001

## АЙКИ ДО

Айкидо -г үндэслэгч нь Японы их мастер Марихэй Уэсида юм. Марихэй өөрийн эцгээс самуурайн шинж чанар болох шийдэмгий дайчин чанарыг, эхээсээ урлаг яруу найраг, шашин шүтлэгт бодитойгоор хандахыг өвлөн авсан болно. Айкидо -гийн гол зорилго нь өөрийгөө хамгаалах бөгөөд бие сэтгэлзүйгээ удирдан жолоодох урлагт суралцах явдал юм.

Айкидо -гийн анхдагч үндэс нь шууд чигээрээ давших хөдөлгөөний тэгш байдлаас гурвалжин болон тойрох хөдөлгөөнд шилжих буюу эсрэг этгээдийн цохилтын хүчийн 90% -ийг ашиглах ба зугатах төвд тэнцүүлэх хүчийг биедээ агуулдаг болно.

## БАЙЛДААНЫ САМБО<sup>2</sup>

Байлдааны самбо нь I Петр хааны үед цэрэг офицеруудын сэлэм жадаар байлдах нарийн аргыг сурч байсан тэр үеэс үүссэн гэж үздэг.

Оросын их жанжин Суворов байлдааны самбо хөгжүүлэх үйлсэд маш - /их хувь нэмэр оруулсан бөгөөд түүний шавь Кутузов ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Мөн Оросын нэрт жанжин Ушаков /1747 -1817/ цэргийн биеийн тамирын бэлтгэл болон гар тулааны урлагийг хөгжүүлж байжээ.

1922 онд Степашин нь "самбо" /өөрөө тэмцэх/ гэдэг нэр томъёотой спортыг бие хамгаалах байлдааны урлаг болгож хөгжүүлсэн болно.

Самбо нь дотроо байлдааны самбо, спорт самбо гэж 2 төрөл байдаг ба 1966 онд спортын төрөл болгон хүлээн зөвшөөрүүлсэн байна.

## ЖУДО<sup>3</sup>

Дэлхийн олон улсад уламжлагдаж ирсэн одоогийн янз бүрийн барилдааны спорт нь хэд хэдэн мянган жилийн түүхтэй бөгөөд тэдгээрийн дотор жудо барилдааны үндэс эхлэл нь Японы үндэсний барилдаан болох сумо барилдаан билээ. Анх Японд үүссэн сумо барилдаан нь цэрэг дайны зорилготойгоор тусгай өмсгөлгүй, ямар ч хувцасгүй барилддаг байв.

Японд цэрэг, дайны зориулалттай "жиу жи цу" гэдэг бие хамгаалах урлаг үүсэн салсан байна. Жиу жи цу нь барилдааны шинж чанарыг тусгасан өөрийн мэх /техник/ хамгаалалт, өөрийгөө хамгаалах аргууд

<sup>2</sup> ЦС Динамо "Самбо", Москва, 1970

<sup>3</sup> Михал Вахун "Дзюдо", 1983



бүхий бие даасан барилдааны нэгэн төрөл болсон байна. Жиу жи цу -гийн анхны сургуулийг 1532 онд Хисамори гэдэг хүн байгуулжээ.

Жиу жи цу -гийн олон зуун сургууль байсан ба энэ барилдаанаар хичээллэж байсан хүмүүсийн дотроос Жигаро Кано /1860 -1938/ жудо барилдааныг шинээр салгаж жинхэнэ бие даасан спортын барилдааны төрөл болгон хөгжүүлсэн. Жу гэдэг нь "уян хатан", до гэдэг нь "арга зам" гэсэн утгатай үг юм.

## ЖИУ ЖИ ЦУ

XVI зуунд каратэгийн орон болох Японд зэвсэггүйгээр тулалдах, бие хамгаалах байлдааны урлагийн шинэ хэлбэр үүсэн хөгжжээ. Энэхүү шинэ төрөл нь гар хөлний үеийг өчих, нугалах мэхүүд дээр тулгуурлан эсрэг этгээдийн биеийн бусад зарим хэсгүүдийг өчих мэхийг хэрэглэдэг байна. Жиу жи цу -г шинэчлэн сайжруулсан хүн бол Японы эмч Акуяма юм. 1882 онд Японы багш Жигаро Кано жиу жи цу -гээс аюултай цохилтын техник элементийг хасаж одоогийн дэлхий даяар тархсан жудо -г үүсгэсэн.

## МОНГОЛ БӨХ<sup>4</sup>


Монгол үндэсний эрхэмлэн бахархаж байдаг эрийн гурван наадмын бөх барилдах, сур харвах, морь уралдуулах уламжлалт тэмцээнээс хамгийн түрүүнд бөхийн барилдаан нь үүсжээ. Эртний хүмүүс эр бие чадлын хүчээр хоолоо олж идэн араатан жигүүртэнтэй тэмцэлдэж амь биеэ хамгаалж байсан ба омог бүлгээрээ анд гарч араатан амьтныг мод чулуугаар намнаж байжээ. Анд гарахын өмнө анчид чулуу шидэх, мэргэ онох, ноцолдож барилдах зэргээр тэмцэлдээн хийж бүгдийг давамгайлсан хүчтэн ан авлагчдын тэргүүн болох, ан гөрөөнд олз омог олсныхоо дараа баяр хөөр болж цовхорч ноцолдож байснаар бөхийн барилдааны эх үүсвэр тавигдсан ба монгол бөхийн барилдаан хуучин чулуун зэвсгийн үе буюу одоогоос 20000 жилийн өмнө үүссэн гэж үздэг.

## МОНГОЛ ЗОО

Монгол оронд ардчилсан төр засаг тогтож бие хамгаалах урлагын олон урсгал чиглэл хөгжсөн ба үндэсний бие хамгаалах арга мэхийг боловсруулах гэж "баньд зо", "монгол зодоон", "монгол каратэ" зэрэг нэр томъёог гаргаж ирсэн. Багш Д.Отгонбаяр нь өөрийн хичээллүүлж байсан дугуйлан болон цаашдын ирээдүйн зорилтоо тодорхойлж монгол хүний бие бялдар сэтгэл зүйд тохирсон үндэсний онцлогтой зодооны төрөл гарган хөгжүүлэхээр шийдэж, үндэсний бие хамгаалах урлаг буюу "монгол зо" төрлийг 1996 онд албан ёсоор үүсгэн гаргасан.

<sup>4</sup> Г. Эрдэнэ "Барилдах ур", 1992

## ХОЁРДУГААР БҮЛЭГ



БИЕ ХАМГААЛАХ ТАКТИКИЙН  
ОЙЛГОЛТ, АГУУЛГА, БҮТЭЦ


## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### БИЕ ХАМГААЛАХ ТАКТИКИЙН ОЙЛГОЛТ, АГУУЛГА, БҮТЭЦ

Бие хамгаалах тактик нь сурган хүмүүжүүлэх ажлын нэгэн чухал чиглэл болохын зэрэгцээ албаны бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх үндсэн элемент болдог.

### АЛБАНЫ БЭЛТГЭЛ

Албаны бэлтгэл гэдэг ойлголт нь албан үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зэвсэг техник болон алба хаагчийн хувийн бэлэн байдлыг хэлнэ. Бэлэн байдлыг дотор нь гурав ангилж үздэг. Үүнд:



**Зэвсэг техникийн бэлэн байдал** гэдэг нь албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай хэрэгсэл, холбооны техник, галт зэвсэг, тээврийн хэрэгсэл зэргийг ажилд байнга бэлэн байхыг хэлнэ.

**Албан хаагчийн бие бялдарын бэлэн байдал** гэдэг нь албан үүрэг гүйцэтгэхэд эрүүл мэндийн болон бие бялдарын хувьд хангагдсан, бэлтгэгдсэн байдлыг хэлнэ.

**Сэтгэл зүйн бэлтгэл хангагдсан байдал** гэдэг нь тухайн алба хаагч аливаа зүйлийг "би чадна", "би ялна" гэсэн итгэлийг бат олж авсан байхаас гадна, айх сандрах гэдгийг үүрд мартан, өөрийгөө хэзээд тайван байдалд байлган шаардлагатай үед хэрэгтэй зөв шийдлийг түргэн хугацаанд гаргах чадварыг хэлнэ.

Дээрхи гурван бэлэн байдал нь цогц байдлаар хангагдаж байж албаны бэлтгэл бий болно.

### БИЕ ХАМГААЛАХ ТАКТИКИЙН ОЙЛГОЛТ

Бие хамгаалах тактик гэдэг нь хууль эрх зүйн хүрээнд хэрэглэгдэж болох тулалдах бүх урсгал чиглэлийн хамгийн сонгомол арга мэхийн нийлмэл цогцыг хэлнэ.

|                  |   |
|------------------|---|
| <b>Бие</b>       | -бие гэдэг нь өөрийн болон бусдын амь нас, бие эрхтэн хууль ёсны бусад эрх ашгийг илэрхийлнэ            |
| <b>Хамгаалах</b> | -өмгөөлөх, халхлах, далдлах утгыг агуулна.  |
| <b>Тактик</b>    | -байлдах ухаан, тулааны үед цэрэг удирдах арга мэх, тавьсан зорилгодоо хүрэх тэмцлийн арга <sup>5</sup> |

### Тактик

Тодорхой зорилгод хүрэхийн тулд дагаж мөрдөх арга зам болон энэхүү арга замыг хэрэгжүүлэх явцад тохиолдох саад бэрхшээлүүдийг даван туулахын тулд хийгдэх бие бялдрын, сэтгэл зүйн, зөөвөрлөлтийн /тээвэрлэлтийн/ холбогдолтой төлөвлөлт болон түүний хийж гүйцэтгэх үйл ажиллагааг хэлнэ. Зорилгод хүрэхэд хэрэглэгдэх тактикуудыг бүхэлд нь стратеги гэнэ. Тактик нь төлөвлөсөн стратегийн хэрэгжилтийн нэг хэсэг юм. Хамгаалагч субъект өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, хууль ёсны бусад эрх ашиг, сонирхолыг гэмт этгээдийн халдлага, довтолгооноос хамгаалах зорилгод хүрэхэд ач холбогдолтой.

### Тактикийн ач холбогдол

Цагдаагийн албан хаагчдад амьдралынх нь бүх үе шатанд тактикийн хэрэгцээ маш их байдаг. Сургуульд ерөнхий болон мэргэжлийн холбогдолтой маш их мэдээлэл олгодог. Энэхүү мэдээллүүд нь мэдээж маш их үнэ цэнэтэй мэдээллүүд юм. Гэвч та энэхүү мэдээллүүдийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ойлголтгүйгээр өөрт ноогдсон үүргээ бүрэн гүйцэд хийж гүйцэтгэх боломжгүй юм. Үүрэг даалгавар гүйцэтгэх явцдаа сурсан мэдлэг чадварыг маш оновчтой хэрэглэж чадах үгүй нь боловсруулсан тактикуудтай тань нягт холбоотой юм.

## БИЕ ХАМГААЛАХ ТАКТИК ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА, БҮТЭЦ

### Эрхэм зорилго

Бие хамгаалах тактик хичээлийн зорилго нь сонсогчдын бие бялдыг хөгжүүлэн сэтгэл зүйн өндөр чадвартай, гардан тулааны арга мэхүүдийг хууль эрх зүйн хүрээнд хэрэглэх мэдлэг, чадвар, дадлыг бүрэн эзэмшсэн цагдаагийн ажилтан бэлтгэхэд оршино.

### Зорилго

Сонсогчдоор гардан тулааны бүх урсгал, чиглэлийн онолыг шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх, сэтгэл зүй, онол арга зүйн талаас нь судлуулах, хичээл бүхэн нь сонсогчдод тодорхой хэмжээний хөдөлгөөний чадвар дадлыг системтэйгээр олгож, тэдний бие бялдрын түвшинг дээшлүүлэн, улмаар бие махбодын галбир тогтоц,

<sup>5</sup> Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв "Орос-Монгол толь", 1982

хэлбэрт өөрчлөлт оруулан тэвчээр хатуужил, эр зоригийн хүмүүжил олгох, довтолгооны хэр хэмжээг зөв үнэлж тодорхой арга мэхийг сонгон хэрэглэхэд сургах, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн зорилт, чиг үүргээ биелүүлэх чадвар, дадалтай цагдаагийн мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх явдал юм.

### Хичээлд тавигдах шаардлага, залгамж холбоо

Бие хамгаалах тактик хичээл нь бүх төрлийн тулалдах арга ухааныг судлаж сургахаас гадна бие бялдрын бэлтгэлжилт, эр зоригийн хүмүүжил олгох, өөртөө итгэх итгэлийг төрүүлдэгээрээ бусад хичээлээс онцлогтой. Энэхүү хичээл нь ерөнхий эрдмийн болон зэвсэг, тусгай хэрэгсэл, эмнэлгийн анхны тусламж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тактик, сэтгэл зүйн хичээлүүдтэй нягт холбоотой байдаг. Сургалтыг тусгай шат дараалсан программын дагуу зааж сургах нь хичээлийн шаардлага юм.

### Бие хамгаалах тактик хичээлийн бүтэц

Бие хамгаалах тактик хичээлийн бүтэц нь доорхи байдлаар ангилагдана. Үүнд:

1. Каратэ, байлдааны самбо, таэквондо, бокс гэх мэтчилэн гар хөлеөр довтлох техникийн голлодог бүх урсгал чиглэлээс
2. Монгол бөх, жудо, самбо, айкидо гэх мэтчилэн барьц авах,

### Хичээлийн төрөл



3. боох, өчих, шидэх техниктэй бүх урсгал чиглэлээс Галт зэвсэг, тусгай хэрэгсэлийг хэрэглэх, эзэмших гэсэн 3 төрөлд ангилан авч үзэн дээрхи төрлүүдийн сонгомол мэхүүдийг нэгтгэн хичээлийн төлөвлөгөөг боловсруулна.

### Хичээлийн ач холбогдол

Энэ төрлийн хичээлээр байнга хичээллэснээр:

1. Цагдаагийн алба хаагч эрүүл чийрэг бие бялдартай байх
2. Албаны бэлэн байдлыг хангах /үүрэг гүйцэтгэх чадвартай/
3. Гадны халдлагаас өөрийгөө болон бусдыг хамгаалах /сэтгэл зүйн бүрэн бэлтгэлтэй байх/

### МЭХ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 7-д "... нийгмийн хэв журмын бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь Засгийн газрын үндсэн бүрэн эрх, Засгийн газрын тухай хуулинд зааснаар: "нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх . . . арга хэмжээ авна" гэж тус тус заажээ. Төрийн нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах энэхүү үүргийг Цагдаагийн байгууллага нь хуулинд заасан үүргээрээ хэрэгжүүлдэг. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 1993 оны сүүлчээр Монгол Улсын Их хурал Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинээр баталсан бөгөөд энэ хуулиндаа цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, харуул хамгаалалт хийх үедээ галт хэрэгсэл болон тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж болохоор тусгайлан заажээ. Уг хуулийн 5 дугаар бүлэг бүхэлдээ Цагдаагийн байгууллага, алба хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэлийн талаар заасан байх бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үедээ цагдаагийн албан хаагчдад галт зэвсэг олгох, алба хаагчид нь уг зэвсгийг биедээ авч явах эрхтэйгээс гадна цэрэг цагдаагийн албанд зориулж үйлдвэрлэсэн нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тээврийн хэрэгсэл ашиглах эрхтэйг заасан. Дээрхи тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх үндэслэлийг Цагдаагийн байгууллагын тухай хуулинд болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 75 тоот тушаалаар баталсан Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх зааварт заасан үндэслэл журмаар хэрэглэнэ. Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх дараах үндэслэлүүд байна.

Үүнд:

- Галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл бүхий бүх тохиолдолд
- Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол
- Гав хүлэггүйгээр хуяглан хүргэх үед зэрэг болно.

Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсоноос бусад нөхцөлд мэх хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний хэвлий дэх ургийг гэмтээж болох мэх хийх
- Тахир дутуу, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний тухайн гэмтлийг сэдрээж болох мэх хийх
- Мэх хийснээс хүний биед гэмтэл учруулж болзошгүй нөхцөлд Эрүүгийн хуулийн гарцаагүй байдлын хэм хэмжээг хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.
- Эхний мэх хийсний дараа мэх хийх үндэслэл арилбал давтан хэрэглэхийг хориглоно.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт "Гэмт хэргийн нийгмийн хор аюулын үгүйсгэх нөхцөл байдал"<sup>6</sup> гэсэн институтыг хуульчилж өгсөн нь нэг талаас тодорхой үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцохгүй зохицуулалт, нөгөө талаас субъектэд эрүүгийн хуулиар олгосон эрх юм.

Тэдгээрээс **Аргагүй хамгаалалт** /Эрүүгийн хуулийн 40 дугаар зүйл/, **Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах** /Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйл/, **Гарцаагүй байдал** /Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйл/, **Тушаал, захирамж биелүүлэх** /Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйл/<sup>7</sup> нь бие хамгаалах арга, мэх хэрэглэх эрх олгосон эрх зүйн үндэс болно.

Тодруулбал дээрхи нөхцөл байдалд хамгаалагч субъект бие хамгаалах арга, мэх, зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэж, эрүүгийн хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх болон бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалах эрх /зарим ажилтан, албан тушаалтанд үүрэг/ олгогдсон бөгөөд тавигдах шаардлага, нөхцөлийн хүрээнд бусдад хор уршиг учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй.

Харин тавигдах шаардлага, нөхцөлийг хангаагүй бол хууль бус болж эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал буй болдог.

<sup>6</sup> Төрийн мэдээлэл, УБ, 2002, дугаар 5, 120 дахь тал

<sup>7</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002, 15, 16 дугаар тал

## ГУРАВДУГААР БҮЛЭГ



**БИЕ ХАМГААЛАХ ТАКТИК**



## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### ДАСГАЛЫН ЭХНИЙ ШАТ

#### БИЕ ХАЛААЛТ

Бие халаалт нь сонсогчдын авах ачаалал, гүйцэтгэх дасгалаас бэртэл авахгүй байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Бие халаалтыг доорхи чиглэлд хувааж болно.

1. **Суллах** -энэ нь бие сэтгэлийн цочроог /стресс/ гаргаж булчингуудын уян хатан байдлыг зохих түвшинд хүртэл нэмэгдүүлдэг.
2. **Нэмэгдэл ачаалал** -үүгээр судасны цохилтыг олшруулж уушигний багтаамжийг нэмэгдүүлэн цусны агуулгуудыг хоослож хялгасан судаснуудыг онгойлгож биеийн ерөнхий халууныг нэмэгдүүлдэг.
3. **Хөдөлгөөн зохицуулах** -үүгээр хөдөлгөөний нарийн дасгалуудыг эхлэх, хариу үйлдэл хийх хурдыг нэмэгдүүлэх, хөдөлгөөн зөв хийж сурах чадварыг дээшлүүлэх зорилготой.
4. **Сэтгэл зүйн бэлтгэл** -үүгээр анхаарлыг төвлөрүүлэх, гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх, зохих хэмжээний урам оруулах зорилготой. Бие халаалтыг ерөнхий, тусгай гэж хуваадаг.

#### ЕРӨНХИЙ БИЕ ХАЛААЛТ

Ерөнхий бие халаалтыг олон төрөл бүрийн спортын дасгал, гүйх, харайх, сунгалтын дасгалуудаар эхлэх нь зүйтэй. Гэхдээ бага эрчээр эхлээд аажмаар нэмдэг. Энэ нь бие организмыг бэлтгэл сургууль хийхэд аажмаар бэлтгэх зорилготой юм. Бие халаалтын энэ хэсэг нь хөнгөн, хөгжилтэй, бага хүч чармайлт гаргахаар байвал зүгээр.

#### ТУСГАЙ БИЕ ХАЛААЛТ

Тусгай бие халаалт нь тодорхой чиглэлээр бэлтгэл сургуулилт хийхэд сэтгэл санаа болон бие бялдрыг бэлтгэх зорилготой. Энд гардан тулааны хөдөлгөөн хийхэд идэвхитэй оролцдог булчингийн төрлүүдийн ачааллах дасгалуудыг хийдэг. Бие халаалтыг 20-40 минут хийх нь зүйтэй. Хэрэв бие махбодыг зохих ёсоор зөв халаагаагүй бол үе мөч мултрах, булчин шөрмөс сунах, тасрах явдал гарч болзошгүй. Энэ нь дасгал сургуулилт хийхэд урт богино, ямар нэгэн хугацаагаар саад болж урьд сурсанаа мартахад хүргэдэг гэмтэй. Довтолгооны хөдөлгөөн техникүүдийг аль болох урт замаар гүйцэтгэхийн тулд таазны үеүүдийг уян хатан байлгахад онцгой анхаарах ёстой. Уян хатан байдлыг тодорхойлох гол хүчин зүйл нь үений сул байдал,

булчин шөрмөсний уян налархай чанар юм. Уян хатан байдлыг идэвхитэй, идэвхигүй гэж ангилдаг. Гадны ачааллын нөлөөгөөр үе мөч хөдөлгөөнд орвол идэвхигүй уян хатан чанар гэнэ. Гадна ачаалалгүйгээр өөрийн булчингийн хүчээр үе мөч хөдөлгөөнд орохыг идэвхитэй уян хатан чанар гэнэ. Жишээ нь ямар нэгэн байдлаар хөлөө өргөхөд энэ чанар илэрнэ. Бие халаалтын дасгалуудыг хийхдээ үе мөч, булчин шөрмөс аль болох хурдан халж суларах тэр чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Учир нь үеүүдийн амплитуд нь өглөө хамгийн бага, үдээс хойш хамгийн их байдаг. Мөн бие халаалт хийхэд орчны хэм багагүй нөлөөтэй.

### УЯН ХАТАН ЧАНАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЕ МӨЧНИЙ ХАЛААЛТЫН ДАСГАЛУУД

- Толгойг хүзүүгээр зүүн, баруун тийш эргүүлэх
- Гарын хурууг дэс дараалан атгаж суллах
- Гарын бугуйгаар гадагш, дотогш эргүүлэх
- Мөрөөр урагш, хойш эргүүлэх
- Бүсэлхийн хэсгээр зүүн, баруун тийш эргүүлэх
- Таазан хэсгээр зүүн, баруун тийш эргүүлэх
- Цээжээр урагш бөхийх, гэдийх
- Өвдөгний үеэр дотогш, гадагш эргүүлэх
- Хелийн шагайг зүүн, баруун тийш эргүүлэх

### СУЛЛАЛТЫН ДАСГАЛУУД

Зэн буюу сэтгэл зүйн дасгал нь суллалтын дасгалд хамаарна. Энэтхэгийн лам Бодитхарма-гийн үндэслэсэн Зэн дасгал нь хүн өөрөө бодол санаагаа зөв удирдах чадвар юм. Энэ нь өнгөц харахад энгийн зүйл боловч угтаа бол их нарийн гүнзгий ойлголт юм. Үүнийг ойлгохын тулд хүний сэтгэл зүйг биенээс нь салган авч үздэг. Гардан тулааны урлагийг эзэмшихээр хичээллэж буй сонсогчийн бие сэтгэхүй хоёр нь дээд зэргээр нийцэн зохицож байх ёстой. Ойлгоход хялбар болгохын тулд сэтгэл зүйн талыг тушаал буулгагч төв, биеийг тушаал гүйцэтгэгч гэж авч үзье. Нэгэн шинэ хөдөлгөөний техникийг эхлэн сурахдаа эхлээд хөдөлгөөнийг тархинаас удирдаж хийхээс өөр замгүй. Тархинаас удирдана гэдэг нь хөдөлгөөний дэс дараа, өндөр нам, туулах замыг сэтгэн бодож найруулж хийнэ гэсэн үг.

Сэтгэн бодож байгаа учраас бид эхэлж сурч байгаа хөдөлгөөнийг удаан хийхэд хүрдэг. Энэ нь сэтгэхүй хөдөлгөөнд саад болж байгааг харуулж байна. Хөдөлгөөний хурдыг нэмж олон дахин давтсанаар тэр хөдөлгөөн хэвшмэл болж хувирах учиртай. Энэ нь тэр хөдөлгөөнийг хийхэд тушаал буулгагч төв /тархи/ хэрэггүй болж тушаал гүйцэтгэгч маань бие даан ажиллах боллоо гэсэн үг. Хөдөлгөөнийг эзэмшсэн

түвшингээс эхэлж сэтгэхүйг зөв эзэмдэн жолоодон удирдах урлагийг судлах ёстой. Хэрэв ямар нэгэн хүнд дасгалыг хийж сурсаны дараа тэр дасгалыг хийж чадах болов уу, үгүй болов уу гэсэн бодлоос бүрмөсөн ангижирч анхаарлаа өөр зүгт хандуулан хийхэд дасгал амжилттай болдог. Аливаа сэтгэлзүйн бэлтгэлийг хөнгөнөөс хүнд рүү, хүндээс хөнгөн рүү хийж эзэмших нь айдсыг дарна. Үүнийг сэтгэл зүйн Зэн төлөв гэнэ. Зэн эзэмшээд хэрэг болсон үед ашиглаж чадсан сонсогч өмнөө тулгарсан саад бэрхшээлийг хялбархан даван туулна.

Бидний мэдрэхүй, сэтгэхүй нэгэн зэрэг зөвхөн нэг л зүйлд анхаарлаа хандуулж чадна. Олон зүйлд анхаарал сарнивал богино хугацаанд сэтгэхүй нэгээс нөгөөд шилжинэ. Гэхдээ энэ шилжилт тодорхой дарааллаар явагдана. Тухайн үедээ хамгийн чухал тэр зүйлдээ анхаарал хандуулдаг. Жишээ нь амь насанд аюул тулгарсан үед амиа хамгаалах нь нэн тэргүүний зорилго учир үүнд бүх анхаарлаа төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулна. Энэ тохиолдолд онцын гол чухал биш зүйлүүд тухайлбал бага зэргийн шарх, шалбархайг мэдэлгүй өнгөрдөг. Бэлтгэл хийхдээ сэтгэхүйгээ жолоодон айх эмээх, өвдөхөөс анхаарлаа зориуд салгаж хийж буй техникдээ бүх анхаарлаа төвлөрүүлж сурдаг. Үүнийг сэтгэлзүйн Зэн төлөвт хүрлээ гэж үздэг.

Зэн төлөв нь сэтгэхүйгээс ангид бус харин сэтгэхүйгээр дүүрэн ба бодол санаагаа удирдан чиглүүлсэн тэр байдал юм. Бэлтгэл хийхийн өмнө ба хийсний дараа "муксуо" командаар Зэн дасгалыг хийдэг. Зэн дасгал буюу бясалгалд өөртөө аятайхан байх ямар нэгэн зүйлийг бодож төсөөлж өөрийгөө амрааж болно. Эхлээд танхимд нам гүм байдалд энэ дасгалыг хийж сураад дараа нь хүндрүүлж чимээ шуугиантай нөхцөлд хийж сурна. Энэ нь хичээллэгч нь ямар ч нөхцөлд анхаарлаа төвлөрүүлж чадах тэр чадварыг төлөвшүүлэхэд тус болдог. Бэлтгэлийн өмнө хойно хийдэг анхаарлыг төвлөрүүлэх дасгал хийхдээ хичээллэгч нь бүх төрлийн гадны /ажил, гэр бүл, найз нөхдийн хүрээний/ нөлөөллөөс сэтгэхүйгээрээ ангижирсан байх ёстой. Бэлтгэлийн танхимд түүний тархи сэтгэхүйд хамгаалал, довтолгооноос өөр юу ч байх ёсгүй. Түүний тархи сэтгэхүйгээсээ гардан тулаанаас бусдыг арчих хэрэгтэй гэсэн үг юм.

Оюуны йогчид анхаарлаа төвлөрүүлэх урлагийг дээд зэргээр эзэмшсэн байдаг. Сэтгэхүйн Зэн түвшинг эзэмшихэд биеийг суллаж биеийн хэмийг нэмэгдүүлж, зүрхний цохилт, амьсгалаа жигдэрүүлэхэд сургадаг йогийн болон өөрөөр өөртөө итгэх урлаг буюу /аутоген/ дасгалууд их тус болно. Энэ дасгалыг хоолоо шингээсний дараа бие барьсан гадуур хувцасаа тайлсаны дараа хэвтээ байдалд буюу түшлэгтэй сандалд арагш гэдийсэн, эсвэл ширээн дээр гараа тавьж толгойгоо дэрлүүлсэн байдалд хийж болно. Энэ дасгал нь бие махбодод оруулах өөрчлөлтийг чангаас сулд, зөвхөн бодолдоо олон

дахин давтан хэлсэн командууд /тушаалууд/ -аар дамжуулан хэрэгжүүлдэг юм.

## АМЬСГАЛЫН ДАСГАЛУУД

Гардан тулаанд зөв амьсгалах, зөв суух, хөдлөх зэргээс эхлэн зөв сэтгэл, зөв дадлаар сэтгэцийг цэгцрүүлэн улмаар сэтгэлээрээ биеийг жолоодож, эрүүлжүүлэх, цаашид чийрэгжих, улмаар жирийн хүний хэвийн чадвараас хэтийдсэн чадвар эзэмшихийг шаарддаг. Зөвхөн амьсгалын зөв техник эзэмшсэн нөхцөлд булчингууд суларч хүчилтөрөгчийн хэрэгцээ хангагддаг багагүй хугацаагаар ачаалал өгөх боломж гардаг. Гүйцэд амьсгалын дасгал нь сэтгэлийн догдлол түгшүүрийг арилгадаг.

### **Бүтэн амьсгал /Эбукү/**

Энэ нь нэг дор нягтарч цугларсан агаар даралтаар дээшээ цээжний хөндий, эгэм хоолой, улмаар гар луу доошоо сууж, хөл рүү урсдаг. Энэ урсгал нь биеийн гол хэсэг чангалж хөшсөний улмаас биеийн бүх хэсэгт чангарч, чичирч салгалах хүртэл үргэлжилдэг. Эбукү -г хэвлийн булчингуудыг чангалсанаас шахагдаж гэдэсний гүнээс амьсгал гарна. Сул тавих чангарах хоёрт ялгааг олох хэрэгтэй. Амьсгалыг тулааны үед 1. амьсгалаа хурдан авч удаан гаргах, 2. амьсгалаа аахилах маягаар хурдан авч хурдан гаргах.

### **Хагас амьсгал /Нагори/**

Дасгалуудын дунд амарч байхдаа аль болох түргэн сэргэхийн тулд нагори амьсгалын дасгалыг хийдэг. Энэ дасгалыг хоёр өөр амьсгалын хэлбэрийг угсруулж хийдэг.

#### 1. Гаднах нагори

Хамраараа амьсгал авч амаараа хурдан гаргана.

#### 2. Доторхи нагори

Хамраараа гүнзгий амьсгалыг 2 -3 секундэд хурдан авч амьсгалаа түгжинэ. Амьсгал авах явцад гарыг доороос цээжний өмнө авчирч хэвтээ тойрог үйлдэн урагш түлхэж нийлүүлэх ба гарыг удаанаар дэлгэх явцад амьсгалаа гаргаж дуусгана.

### **Киа /ишо/**

Энэ нь амьсгалын бас нэгэн хэлбэр учир үүнийг амьсгалын дасгалуудтай хамт авч үзэх нь зүйтэй юм. Энэ нь гардан тулааны явцад хашгирдаг нэг ёсны уухай. Энэ уухай нь хоёр янзын ашиг тус үзүүлнэ. Цагийг нь олж хийсэн хүчтэй уухай нь эсрэг этгээдээ сэтгэл зүйн хувьд цочирдуулдаг. Түүгээр ч барахгүй хэдхэн хормын хугацаанд балмагдуулан сандралд оруулах явдал ч гардаг. Нөгөөтэйгүүр уухайлах нь хүнийг сэтгэл зүйн хувьд бэлтгэхээс гадна хүчийг

нэмэгдүүлдэг. Мөн сэтгэлзүй, бие бялдрын хувьд өөрөө өөртөө итгэх итгэлийг бий болгож өгдөг. Үүнээс гадна сонсогч уухайлсанаар эсрэг этгээдээс сүрдэх, эмээх нь багасдаг. Уушигнаас гарах агаараар хоолойн дууны хөвчийг савлуулдаг. Жишээ нь уухай нь өдөр тутмын амьдралд байдаг хашгираанаас өөр юм.

Уухай нь хэвлийн булчинг чангалсанаар ходоодноос гэнэт шахагдан гарах агаарын дуу авиа юм. Уухай хийх агшиныг зөв сонгох нь чухал юм. Уухайг хийхэд булчин шөрмөс чангардаг тул түүнийг техник хийж байх явцад биш түүний төгсгөлд бүх булчин шөрмөсөө чангалах үед хийх нь зүйтэй.



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ



ҮНДСЭН ТЕХНИК

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### ҮНДСЭН ТЕХНИК

#### ЗОГСОЛТЫН ТЕХНИКҮҮД


Бие хамгаалах тактикт суралцахын тулд юуны өмнө зогсолтын техникийг маш зөв хийж сурах хэрэгтэй. Үндсэн зогсолтын техникүүдийг гүйцэтгэх явцад биеийн зөв төрх /поза/ хүндийн төвийн зөв байрлалыг бий болгох явдлыг чухалчилдаг. Зогсолтыг техникүүдийг сурахад анхаарах гол нэг зүйл бол хүндийн төвөө үргэлж нэг түвшинд /өндөрт/ хадгалж үлдэх явдал юм. Энэ нь хүний нүд босоо хэвтээ чиглэлийн шилжилт хөдөлгөөнийг амархан ажигладаг боловч гүний чиглэлийн шилжилт, өөрчлөлтийг тийм ч амархан ажигладаггүйтэй холбоотой юм. Дээр хэлсэнээр хүндийн төвөө нэг өндөрт барьж сурвал эсрэг этгээдэд хялбарханаар дөхөж очиж чаддаг. Зогсолтоос эргэхдээ эхлээд алхах гэж байгаа хөлийг зөөж тавиад бат тулаад энэ хөл дээрээ эргэх нь зүйтэй.

Зогсолтын маш олон хувилбар байдаг бөгөөд үүнээс гол хэрэглэгддэг зогсолтын техникүүдийг авч үзье.

#### 1. Үндсэн зогсолт /фуда дачи/

Хоёр хөлийн өсгий мөрний хэмжээтэй зайтай, өлмий гадагш чиглэсэн байдалтай, гар зангидсан, тохойгоор бага зэрэг нугалсан, бүсний өндөрт паралель байдалтай байна.

Зураг 1




#### 2. Нуман зогсолт /санчин дачи/

Энэ зогсолтоор зогссон хүний биед 23 ширхэг гурвалжин дүрслэгдэн харагддаг учраас үүнийг гурвалжин зогсолт гэж нэрлэнэ. Дотогш тавьсан өлмийнүүдийн таазыг чөлөөтэй эргэх боломжоор хангадаг учраас энэ зогсолтоор алхалт хийхгүй, гарын техникүүдийг давтдаг юм. Хөл, гуя, ахар сүүлний булчинг чангална. Энэ зогсолтонд хийсэн

хөлийн хөдөлгөөн дугуй замаар хийгдэх ба хоёр гараар хамгаалалтын хөдөлгөөн хийнэ.


Зураг 2



### 3. Давшилт хийх зогсолт /зенкүцү дачи/

Энэ зогсолтыг ихэвчлэн довтлох техникт хэрэглэнэ. Хоёр хөл ойролцоогоор нэг мөрний хэмжээний өргөн, хоёр мөрийн хэмжээний урт байрлалтай байна. Урд талын хөл чанх урагш чиглэлтэй, өвдөг нугалсан байна. Хойд талын хөл чанх урагш чиглэсэн 45 хэм хазайж гадагш чиглэсэн байна. Урьд талын хөлд биеийн жингийн 60 хувийг, хойд талын хөл дээр 40 хувь байх ёстой. Энэ зогсолтоор алхахад урд талын хөлний өсгий дотогш 45 хэм цөмөрч хойд хөл чанх урагш чиглэлтэй байна.

Зураг 3






#### 4. Морин зогсолт /киба дачи/

Энэ зогсолтыг довтлох, хамгаалах техникүүдийн үед хэрэглэнэ. Гуяны булчингуудыг хүчитгэж сүүжний үеүдийг суллах ач холбогдолтой. Энэ зогсолтын өргөн хоёр мөрний хэмжээний ба сүүж доош нилээд суусан, өвдөгнүүд гадагш хөшсөн байдалтай байна. Нуруу шулуун байна. Биеийн жин хоёр хөл дээр 50, 50 хувь хуваагдана. Энэ зогсолт нь 45 ба 90 хэм гэсэн хоёр янз байна. 45 хэмийн киба дачийн урагшлах хөдөлгөөн нь зенкүцү дачи -тай адил байна. 90 хэмийн киба дачи -д урагшлахдаа талаа солихгүйгээр хөлөө хойно урд зөрүүлнэ. Талаа солихдоо эхлээд урагшлах зүг рүү харж хөлөө урагш тавин цээжээрээ бүтэн эргэж шинэ зогсолтоор зогсоно.


Зураг 4



#### 5. Тулааны зогсолт /моро аши дачи/

Энэ зогсолтыг гэнэт урагш гишгихээс хамгаалахад хэрэглэнэ. Японы сэлмийн байлдааны толгой цавчихад хэрэглэж байсан зогсолтыг авч хэрэглэжээ. Зогсолтын урт нэг тавхай, өргөн нь мөрний хэмжээтэй, хоёр хөл паралель байдалтай байна. Биеийн жин хоёр хөл дээр 50, 50 хувь хуваагдана. Энэ зогсолтоор урагшлахдаа дэгдэх байдлаар гүйцэтгэнэ.

Зураг 5



## ӨНХРӨЛТ, УНАЛТЫН ТЕХНИКҮҮД

### Өнхрөлтийн дасгал

Өнхрөлтийн дасгал нь уналт хийх эхний үе шат гэж ойлгож болно. Өнхрөлт нь зарим тохиолдолд уналтын үүргийг гүйцэтгэх явдал байдаг. Өнхрөлтийг зөв хийж сурсанаар уналтыг хийх нөхцөл бүрдэнэ. Өнхрөлт хийхэд гол анхаарах зүйл бол толгойг цээжнээс салгахгүй байх явдал.

### Өнхрөлтийн техникүүд

#### 1. Урагш өнхрөх

Хөлөө өвдгөөрөө нугалж гараараа газар тулж эрүүгээ цээжинд тулгаж биеийнхээ жинг урагш төвлөрүүлж өнхөрнө. Өнхрөхдөө нугалсан хөлөө гараараа барьж эхний байрлалд орно.

Зураг 6



#### 2. Арагш өнхрөх

Хөлөө өвдөгөөрөө нугалаад, гараараа газар тулж биеийнхээ жинг арагш төвлөрүүлж эрүүг эгэмд нааж нуруугаараа эргэнэ. Өвдөгөө цээжиндээ тулгаж тохойгоороо нугалсан гараа толгойн ард байрлуулж гарын алгаараа газар тулаад толгойгоороо эргэж анхны байрлалд орно.

Зураг 7




## Уналтын техникүүд

Уналтын техникийн маш нарийн зөв ойлгож хийх ёстой. Сайн ойлгож хийгээгүйгээс уналт буруу болж гэмтэх явдал гарна. Уналтын гол ач холбогдол нь зөвхөн өөрийн бие махбодыг бэртэл гэмтлээс хамгаалахад оршино.

### 1. Урагшаа эгц уналт

Босоо байрлалаас эгцээр урагш унаж дэвжээнд унах үедээ гарыг тохойноос урагш дэвжээ цохиж өлмий дээр, цээж болон хэвлий хөндий байрласан байх ёстой.

Зураг 8



### 2. Самбо уналт

Зүүн хөлөө урагш тавьсан тохиолдолд зүүн гараа, баруун хөлөө урагш тавьсан тохиолдолд баруун гараа урагш сунган хурууны үзүүрээс дал хүртэл тойрог үүсгэж далаар тулж өнхөрнө. Унах үед эсрэг гараар дэвжээ алгадна. Гарын байрлал мөр дагаж унжсан байрлалтай байна.


Зураг 9



### 3. Хажуугийн уналт

Хагас суугаа байрлалаас зүүн баруун аль ч тал руу унаж болно. Хагас суугаа байрлалаас зүүн талаар унахад зүүн хөлөө урагш шидэж хүндийн төвөө даланд төвлөрүүлж мөн дэвжээ алгадаж унана.

Зураг 10



### 4. Арагшаа уналт

Хагас суугаа байрлалаас арагш унахдаа далаар хүрэхэд хоёр гараараа мөрний дагуу байрлалаас дэвжээ алгадна. Толгой эрүү цээжнээс салахгүй наалдаж байна.


Зураг 11



### 5. Цэгийн эргэлттэй уналт

Урагш өлмий дээрээс түлхэж агаарт хий эргэж далаараа унан арагш уналтын адил дэвжээ алгадаж унана.

Зураг 12




## ГАРЫН ЦОХИЛТЫН ТЕХНИК

Гарын цохилт нь 120 төрлийн цохилт байна. Үүнээс гол хэрэглэгдэх цохилтын техникуудыг авч үзье. Юуны өмнө гарыг зөв атгаж сурах хэрэгтэй. Гарын хуруунуудыг үений дагуу жигд хийгүй атгах буюу эрхий хуруугаар долоовор дунд хуруугаар дарсан буюу түгжсэн байдлаар атгана. Цохилтыг зөв хүчтэй хийж сурахад зөвхөн гарын техникт анхаарлаа төвлөрүүлэх биш хөлийн байрлалаас цохилтын эцсийн цэг хүртэл хүчээ мэдэрч цохих нь цохилтын техникийн бүрэн дүүрэн амжилттай болох үндэс нь болж өгнө.

### 1. Шулуун цохилт

Зураг 13




### 2. Өлгөж цохих

Зураг 14



## 3. Атгасан гарыг өлгөж цохих

Зураг 15



## ГАРЫН ХАМГААЛАЛТЫН ТЕХНИКУУД

Гарын хамгаалалтыг зөв техникийн дагуу хийж сурвал хамгаалалт нь аажмаар цохилт болж хувирдаг. Эхлэн суралцагч маань бүх хөдөлгөөнийг маш нарийн тогтоож удаан хөдөлгөөнөөс хурдан хөдөлгөөнд шилжих маягаар давтаж дадал зуршил болгох нь ач холбогдолтой. Гарын хамгаалалт олон төрөл байдаг. Үүнээс үндсэн 4 төрлийн хамгаалалтыг авч үзье.

*Жич: Гарын цохилт, хөлийн өшиглөлтийг амжилттай хийж гүйцэтгэхэд биеийн хүчний бэлтгэл маш их нөлөөтэй.*

## 1. Саравчилж хамгаалах

Зураг 16



## 2. Гаднаас дунд түвшинд хамгаалах

Зураг 17



### 3. Дотроос дунд түвшинд хамгаалах Зураг 18



### 4. Доод түвшинд хамгаалах Зураг 19



## ХӨЛИЙН ӨШИГЛӨЛТҮҮД

Хөлийн өшиглөлтийг хийхийн тулд уян хатан чанар тодорхой хэмжээнд нөлөө үзүүлнэ. Үүнээс гадна хүндийн төвөө зөв байрлуулж сурсанаар /тэнцвэрт байдал/ өшиглөлт зөв болж өгнө. Хөлийн өшиглөлтийн техник хийхдээ өвдөгний гаралт, таазаа маш сайн хянаж хийж сурах нь өшиглөлтийн техникийг зөв хийж сурахад ач холбогдолтой. Хөлийн өшиглөлтийн техникийг эзэмшихийн тулд маш олон удаа давтах хэрэгтэй.


### 1. Доод түвшинд өшиглөлт

Зураг 20




2. Эгц шулуун өшиглөлт

Зураг 21




3. Хажуугийн өшиглөлт

Зураг 22



4. Арагш өшиглөлт


Зураг 23






## 5. Хажуугаас алгадаж өшиглөх

Зураг 24



## 6. Эргэлттэй өшиглөх


Зураг 25

**ХИЙСВЭР ТУЛААН /КАТА/**

Ката гэдэг нь өөрийн үл үзэгдэх өрсөлдөгчөө сэтгэл санаандаа хийсвэрлэн төсөөлж гардан тулалдаж байгаа хөдөлгөөнийг хэлнэ. Катаг хийснээр хөдөлгөөний эвсэл сайжирч, хараа хурд нэмэгдэхээс гадна үндсэн техникийг гардан тулаанд хэрэглэх дадал зуршил бий болж өгнө. Ката нь маш олон төрөл байдаг, мөн өөрөө зохиож хийж болдог. Үүнээс эхлэн сурагчийн ката буюу сурагчийн ката "Тайкиоку соно ич" -ийг авч үзүүлье.

*"Тайкиоку соно ич" ката -гийн утга учир*

Тайкиоку -/анхдагч шалтгаан, агуу их хязгаар/, "Хятадын тайчи" -тай стэй. Энэ ката -г Гичин Фунакаши зохиожээ. Их мастер Мас Ояама хэлэхдээ: Хүүхэд хөлд орж байгаатай адил каратэ сурч байгаа хүн хөлийн гишгэлт, тэнцвэрээс эхэлнэ. Тайкиоку ямар нэг юмны хэсэг дээр анхаарлаа төвлөрүүлэх биш бүхэл бүтнээр нь хардаг.





13



14



15



16



17



18



19



20



21



22



23



24



25



26



27



28



29



30



31



32



33




34



35

## ТАВДУГААР БҮЛЭГ




ХАМГААЛАХ, НЯЦААЛТ ӨГӨХ  
АРГУУД

## ТАВДУГААР БҮЛЭГ

### ХАМГААЛАХ, НЯЦААЛТ ӨГӨХ ТЕХНИК

#### 1. Гарын цохилтыг хамгаалах нь


Зураг 27



#### 2. Хөлийн өшиглөлтөөс хамгаалах нь


Зураг 28





БАРЬЦНААС ЧӨЛӨӨЛӨХ АРГУУД

Зураг 29







**АМЬСГАЛ БООХ АРГУУД**

Зураг 30

Араас хоёр гараар  
шахаж боох



Араас гарын +  
нарийн шуугаар  
хоолойг шахаж боох



Хувцасны захаар  
зөрүүлж боох

Урдаас шахаж  
бооох



Хувцасны  
захаар боох




## БАРИВЧЛАХ АРГУУД

Баривчлах арга ажиллагааны хувилбарууд нь тухайн үеийн хэв журмын болон эрүүгийн нөхцөл байдал, гэмт этгээдүүдийн нийгэм, иргэдэд учруулж байгаа болон учруулж болох гэм хор, хөнөөл, зэвсэглэсэн байдлаас шалтгаалан янз бүр байна. Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч нар нь аливаа баривчлах ажиллагаа явуулахдаа галт зэвсэг, хамгаалалтын тусгай хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон холбооны хэрэгслээр хангагдан үйл ажиллагаа явуулна. Зөв тактик, түргэн шуурхай байдал, бие биенээ зөв ойлгож хамтран ажиллах нь чухал. Энэ нь тодорхой гэмт этгээдүүдийг баривчлах тактикт хэрэглэгдэнэ.

### 1. Чагталж баривчлах

Зураг 31




### 2. Сугадаж баривчлах

Зураг 32




### 3. Хайчилж баривчлах

Зураг 33



**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**



**ЗЭВСЭГТЭЙ ДОВТОЛГООНООС  
ХАМГААЛАХ АРГА**

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### ЗЭВСЭГТЭЙ ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ АРГУУД

### ХУТГАТАЙ ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ


#### 1. Дээрээс довтлох үед


Зураг 34



#### 2. Чичиж довтлох үед


Зураг 35





3. Доороос довтлох үед


Зураг 36



БУУТАЙ ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ

1. Урдаас буу тулгасан үед

Зураг 37



3. Араас буу тулгасан үед

Зураг 39



БИЕД ҮЗЛЭГ ХИЙХ, ХҮЛЭГ ХИЙХ АРГУУД

1. Босоо байдалд биед үзлэг хийх, нэгжих

Зураг 40



2. Сөхрүүлж, хагас суулгасан үед үзлэг хийх, нэгжих

Зураг 41



3. Хэвтээ байдалд биед үзлэг хийх, нэгжих

Зураг 42




## ХҮЛЭХ АРГУУД

### Дөрвөлжин хүлэг

Хүлэх оосроос гарган битүү гогцоотой талаар нь нугалаастай гарынх нь бугуйгаар нь урхидан авч, дотор талаас нь гадагш чангалж, зүүн мөрөн дээгүүр нь давуулан гаргаж, цээжээр нь тойруулан гогцоолдож баруун гарын суган доогуур нь гаргаж, баруун гарыг хагас тугавчилж уяад, зүүн гарыг бүтэн тугавчилж уяад, баруун гарын дээш татсан оосроос нэг ороож мөрний ар талд хөврөхөөр уяна.

Зураг 43




Тэлээгээр хүлэх арга

Зураг 44



## ДОЛДУГААР БҮЛЭГ



**НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ  
ХЭРЭГЛЭХ ТАКТИК**



## ДОЛДУГААР БҮЛЭГ

### НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТАКТИК

#### РЕЗИНЭН БОРООХОЙ ХЭРЭГЛЭХ НЬ

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 1994 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 26 дугаар зүйлд "... цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд цахилгаан ба резинэн бороохой, нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу буюу шүршүүр, резинэн ба хуванцар сумтай бууны аль нэгийг хэрэглэж болно" гэж заажээ. Үүнд:


- а. Гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд саад болсон үйлдлээ зогсоох талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй
- б. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаа, шаардлагыг эсэргүүцсэн
- в. Харилцан зодолдож байгаа хүмүүс үйлдлээ зогсоох шаардлагыг зориуд биелүүлээгүй
- г. Цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар эсэргүүцэж болох, мөн хориглож эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, ялтан этгээдийг баривчлах
- д. Сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан оргон зайлах оролдлого хийсэн бол цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн гэж үзэж энэ зүйлд заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.
- е. Нийтийн эмх замбараагүй байдалд оролцож буй этгээдийн үйлдлийг таслан зогсоох ба баривчлах
- ё. Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгаа этгээдийн үйлдлийг таслан зогсоох ба баривчлах
- ж. Байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх
- з. Галт зэвсэг хэрэглэж болох үндэслэл, бүх нөхцөлд

#### РЕЗИНИН БОРООХОЙ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ НЬ

- а. Тусгай хэрэгсэл хэрэглэсний үр дүнд тусгай хэрэгсэл дахин хэрэглэх үндэслэл арилсан бол
- б. 26 дугаар зүйлийн а, б, в -д заасан тохиолдолд резинэн бороохойгоор хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газар цохихыг хориглоно.

Резин бороохойгоор хамгаалах

Зураг 45



## Резин борсохойгоор довтлох аргууд


Зураг 46




## ГАВ ХЭРЭГЛЭХ НЬ

1. Гавыг дараах тохиолдолд хэрэглэж болно.
  - а. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй эсхүл эсэргүүцсэн
  - б. ЦЕГ -ын даргын 1994 оны 75 дугаар тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 13 дугаар зүйлд заасан бүх тохиолдолд гавыг хэрэглэж болно.
2. Гавыг гар, хөл, хуруунд хийж болно. Үүнд:
  - а. Хоёр гарыг урд нь болон ард нь бугуйгаар холбож хийнэ.
  - б. Хөлөнд хоёр хөлийн нарийн шилбээр, эсвэл өвдөгний дээгүүр тушиж хийнэ.
  - в. Хурууны гавыг хоёр гарын эрхий хуруунд хийнэ.
  - г. Хоёр ба түүнээс дээш хүний эрхий хуруу, гар болон хөлийг холбож гавлаж болно.
  - д. Хүнийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгээ холбон гавлаж болно.
  - е. Хүнийг тээвэрлэх үед гар буюу хөлийг автомашины суудал, тэвш, бусад эд зүйлтэй холбон гавлаж болно.
  - ё. Гавыг хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирахааргүй өөр зүйлээс түр хугацаагаар аргамжиж болно.
  - ж. Хүйтний улиралд гавыг гадаа хэрэглэхдээ хөл, гарыг хайрч гэмтээхээс хамгаална.


Гав хэрэглэх арга



Зураг 47



Гавыг барих




Нэг гараас гавлах



Холбож гавлах

Хүргэх арга

## НАЙМДУГААР БҮЛЭГ



НИЙТИЙГ ХАМАРСАН  
ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫГ  
ТАСЛАН ЗОГСООХ ТАКТИК

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ ТАКТИК

#### ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫН ҮЕД “БАГ-БҮЛЭГ-САЛАА” -НЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

##### Эзэмших арга барилууд

Энэхүү бүлгийг судласнаар суралцагсад дараах арга барилуудыг эзэмших болно.

1. Хүч хэрэглэх тактикуудыг тайлбарлах
2. Тактик зохион байгуулалтуудыг ойлгох
3. Тактик зохион байгуулалтуудын төрлүүдийг жагсаах
4. Багийн тактикийн зохион байгуулалтуудыг ойлгох
5. Багийн тактикийн зохион байгуулалтуудыг жагсаах
6. Багийн тактикийн зохион байгуулалтууд хаана хаана хэрэглэгдэх
7. Бүлгийн тактик, зохион байгуулалтыг тайлбарлах
8. Бүлгийн тактик, зохион байгуулалтыг жагсаах
9. Бүлгийн тактик, зохион байгуулалтууд хаана хаана хэрэглэгдэж байгааг ойлгох
10. Салааны тактик, зохион байгуулалтуудыг тайлбарлах
11. Салааны тактик, зохион байгуулалтуудыг жагсаах

##### Гүйцэтгэх дасгалууд

1. Энэхүү бүлэгт багтсан баг, бүлэг, салааны зохион байгуулалттай холбоотой зурагнуудыг нарийвчлан судла.
2. Цагдаагийн баг, бүлэг, салааны зохион байгуулалттай холбоотой сонин, сэтгүүлд нийтлэгдсэн зурагнуудыг ангидаа авчрах
3. Урьд өмнө телевизээр үзэж байсан олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг цагдаа нарын зохион байгуулалттай холбоотой товч тэмдэглэл хийж ангидаа авчир.

##### Дасгал ажлууд

1. Баг гэж юу вэ?
2. Бүлэг гэж юу вэ?

3. Салаа гэж юу вэ?
4. Багийн жагсаалт, зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
5. Багийн үе шат бүхий зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
6. Багийн "КАМА" зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
7. Багийн "Тойрогт" зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
8. Багийн "Нэг эгнээт" зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
9. Багийн "Хоёр эгнээт" зохион байгуулалтын хэрэглэгдэх газруудыг нэрлэ.
10. Баг болон бүлгийн зохион байгуулалтанд багийн удирдагч болон түүний туслах хаана хаана байрлах ёстой вэ?
11. Бүлгийн удирдагч болон түүний туслах хаана хаана байрлах ёстой вэ?
12. Зэвсэгт хэсэгт холбоо баригч болон мэргэн буудагч хаана хаана байрлах ёстой вэ?

### **Тактикийн зохион байгуулалтууд**

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох үүрэгт ажилд оролцож буй цагдаагийн ажилтанууд тактикийг маш сайн хэрэглэдэг байх нь чухал. Хийж буй ажлаа үгээр бус үйл хөдлөлөөрөө илэрхийлж чаддаг байх ёстой. Хүч хэрэглэх явцад ч гэсэн эзэмшсэн ур чадварууд нь ажиллагсадын тоо хэмжээнээс илүү тооцогдох ёстой. Нэгэн системийн дагуу байраа өөрчлөх, урагшлах, ухрах болон тэмцэх явдлууд нь, хүч хэрэглэхийн мөн чанар болон хэм хэмжээ, үйл явдлын аль хэр ширүүн болж байгаатай нягт холбоотой юм.

Ардчилсан эрх, эрх чөлөөгөө эдэлж буй хүмүүс, өөрийн бодол санаа, сэтгэлийн хөдлөлөө нууж чаддаг, юу хийж байгаагаа мэддэг, өөрийгөө бус "цагдаа" гэдгээ илэрхийлэгч, сайн бэлтгэгдсэн цагдааг хараад үйл явдлын хурцадмал байдлыг намжаан ардчилсан эрхээ эдлэхтэй холбоотой ямар нэгэн сэрэмжилсэн байдал нь үгүй болно. Мөн түүнчлэн, олон нийтийг хамарсан эмх замбараагүй явдал нь аливаа адал явдалд дурлагчдын сонирхолын татахаа болино. Иймд хүч хэрэглэх тактикуудын нэг хэсэг болох зохион байгуулалтын талаар ерөнхийлөн дурдах болно. Зохион байгуулалтуудыг багийн зохион байгуулалт, бүлгийн зохион байгуулалт, салааны зохион байгуулалт гэж бүлэглэн үзнэ.

**Баг:** 10 зэвсэглэсэн гишүүнээс бүрдэнэ. Нэг дугаартай гишүүн нь багийн ахлах офицерийн туслах, 10 дугаартай гишүүн нь багийн ахлагчийн туслах бөгөөд хамгийн туршлагатай ахмад цагдаагийн ажилтан байна. Хамгийн эхэнд офицерийн туслах, хамгийн ард багийн ахлагчийн туслах байрлах хэлбэрээр албан хаагчид ар араасаа эгнэн багийн зохион байгуулалтыг үүсгэнэ.

**Бүлэг:** Дөрвөн зэвсэгт хүчний багаас бүрддэг.

**Салаа:** Хамгийн багадаа хоёр зэвсэгт бүлгээс бүрддэг.

## 1. БАГИЙН ТАКТИКИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1 Багийн жагсаалын зохион байгуулалт

- Багийн баруун болон зүүн тийш жагсах зохион байгуулалт
- Багийн баруун болон зүүн тийш бүснээсээ хэлхэлдсэн зохион байгуулалт
- Багийн баруун болон зүүн тийш сугавчлан хэлхэлдэх зохион байгуулалт

#### Тавилт:

Баг эгнээндээ ороод “марш” гэсэн командаар баг бүхэлдээ баруун буюу зүүн тийш эргэж бүх гишүүд нэгэн зэрэг хөдөлж сүүлийн гишүүнээс эхлэн байраа эзэлж багийн зохион байгуулалтанд орно. Эгнээний зохион байгуулалттай багууд ийм хэлбэрээр жагсана.

#### Хэрэглэгдэх газрууд:

- Хөлийн шагайг зүүн, баруун тийш эргүүлэх
- Давчуухан газрыг хааж бүслэх
- Ямар нэгэн байр буюу байршлыг хамгаалах
- Зам хаах
- Олон хүнийг нэг газраас гаргах
- Тал бүрээс ирж буй аюул заналын эсрэг урьдчилан сэргийлэх шаардлагатай үед хэрэглэгдэнэ.




### А. Багийн баруун ба зүүн тийш эгнэн жагсах зохион байгуулалт


**Команд:** Баруун зүүн тийш эгнэн жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Хоёр номерийн албан хаагч заагдсан байрлалаа эзэлж, бусад гишүүд нь түүний баруун зүүн талаар нь зогсож эгнээнд орно. Багийн ахлагч хоёр ба гурван номерийн гишүүдийн, багийн туслагч найм ба есөн номерийн гишүүдийн дараа зогсоно.



Багийн баруун тийш эгнэн жагсах



Багийн зүүн тийш эгнэн жагсах


### Б. Багийн баруун ба зүүн талын мөрөвчинд /palaska/ эгнээний зохион байгуулалт

**Команд:** Баруун зүүн мөрөвчинд эгнээгээр жагсаад марш


**Хэрэгжүүлэлт:**

Энгийн эгнээний зохион байгуулалттай адил /tertiplenr/

Гишүүн бүр зүүн гараа зүүн талынхаа гишүүний баруун гарын араар хийж гараараа найзынхаа мөрөвчнөөс /бүснээс/ чанга бариад, зүүн гар хойно байж, зүүн хөл хагас алхам



Зүүн гараар бүснээс барин эгнэн жагсах





## В. Багийн баруун болон зүүн тийш сугавчлан жагсах

**Команд:** Баг баруун тийш сугавчлан жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Энгийн жагсах байдлаар зохион байгуулагддаг. Бүх албан хаагч баруун гараа баруун талынхаа албан хаагчийн зүүн гарын араар тойруулан хоёр гараа цээжин тушаанаа нийлүүлэн 4 хуруугаараа гараа салаавчлан барина, зүүн хөлөө хагас алхмын өмнө тавьж биеэ бага зэрэг урагш бөхийлгөнө. Биеийн жингээ хоёр хөлөндөө тэнцүүхэн хуваарилна.



*Сугавчлан жагсах*

## Г. Багийн баруун болон зүүн тийш диагональ хэлбэрээр жагсах

**Команд:** Баг баруун тийш диагональ хэлбэрээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Хоёр дугаартай албан хаагч заагдсан чиглэлд байрлалаа эзэлнэ, бусад нь дэс дараалан баруун эсвэл зүүн тийш үе шаттайгаар ухран байрлалаа эзэлнэ. Багийн ахлагч нь 3 болон 4 дугаартай албан хаагчдын ард талд, багийн ахлагчийн туслах нь 8 болон 9 дугаартай албан хаагчийн ард байраа эзэлнэ.

**Тавилт:**

Командын дагуу багийн бүх гишүүд баруун болон зүүн тийш эргэн, нэгэн зэрэг хөдлөн сүүлийн гишүүнээс эхлэн тавигдаж багийн зохион байгуулалтанд шилжинэ.

**Хэрэглэгдэх газрууд:**

- Энэхүү зохион байгуулалт нь зөвхөн урагшлах зохион байгуулалт бөгөөд аюул занал ойртсон үед хэрэглэгдэнэ.
- Олон хүнийг нэгэн тийш чиглүүлэхэд
- Аливаа газрыг хамгаалалтандаа авч урагшлахад

- Жагсан явж буй олон хүнийг замын уулзвар дээр өөр тийш нь чиглүүлэх



Багийн зүүн тийш шатлан жагсах



Багийн баруун тийш шатлан жагсах

## 1.2 Багийн жад хэлбэрийн зохион байгуулалт

**Команд:** Жадан хэлбэрээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2 дугаартай гишүүн заагдсан зүгт байраа эзэлнэ. Тэгш тоон дугаартай бусад гишүүд /4, 6, 8, 10/ нь дэс дараалан 2 дугаартай гишүүний баруун хойд талд, сондгой /3, 5, 7, 9/ дугаартай гишүүд нь 2 дугаартай гишүүний зүүн хойд талд үе шаттайгаар уруу харсан "V" хэлбэртэйгээр байраа эзэлнэ. Багийн ахлагч нь 2 дугаартай гишүүний хойд талд, түүний туслах нь 7, 9 дугаартай гишүүдийн ар талд байраа эзэлнэ.

**Тавилт:**

Команд өгөгдсөний дараа багийн гишүүд бүгд арагш эргэн нэгэн зэрэг хөдлөн сүүлийн гишүүнээс эхлэн сам маягаар зөрөлдөн багийн зохион байгуулалтанд шилжинэ.

**Хэрэглэгдэх газрууд:**

Энэхүү зохион байгуулалт нь зөвхөн урагшлах зохион байгуулалт бөгөөд аюул занал ойртсон үед хэрэглэгддэг.

- Зорьсон газартаа хүрэх
- Олон хүний дундуур зам гаргах
- Олон хүний дундаас нэг хүнийг баривчлах
- Урагшилж буй нэгэн хүний эсвэл бүлгийн урагшлахад туслах

Тойргийн зохион байгуулалтаар баривчлагдсан нэгнийг хүргэхэд



Жад хэлбэрээр жагсах

### 1.3 Багийн тойрог хэлбэрийн зохион байгуулалт

**Команд:** Тойрог хэлбэрээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Нэг эгнээгээр жагсаж буй багийн /2, 4, 6, 8/ дугаартай гишүүд баруун гар талд хагас сар хэлбэртэйгээр, /3, 5, 7, 9/ дугаартай гишүүд зүүн гар талд хагас саран хэлбэртэйгээр жагсан тойрог үүсгэнэ. Багийн ахлагч нь 8 дугаартай гишүүний, түүний туслах нь 9 дугаартай гишүүний ард тойргийн гадна байраа эзэлнэ.

**Тавилт:**

Командын дараа багийн гишүүд эргэн нэгэн зэрэг хөдлөн сүүлчийн гишүүнээс эхлэн сам маягаар зөрөлдөн багийн зохион байгуулалтанд шилжинэ.

**Хэрэглэгдэх газрууд:**

Энэ зохион байгуулалт нь зөвхөн урагшлах зохион байгуулалт бөгөөд аюул занал ойртсон үед хэрэглэгдэнэ.

- Хэн нэгнийг хамгаалах үед
- Үнэт зүйлсийг хамгаалахад
- Бүх зүгээс ирж болох аюул заналаас урьдчилан сэргийлэх
- Олон хүний дундаас хэн нэгнийг гаргахын тулд



Багийн тойрог хэлбэрээр жагсах

#### 1.4 Багийн нэг цуваат зохион байгуулалт

**Команд:** Нэг цуваагаар жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2 дугаартай гишүүн заагдсан зүгт урагшлах бөгөөд бусад нь дугаарын дагуу 2 дугаартай гишүүний хойноос нэгийн цуваанд орж байраа эзэлнэ. Энэ нөхцөлд багийн ахлагч 2 дугаартай гишүүний өмнө, түүний туслах нь цувааны хамгийн ард байраа эзэлнэ.

**Тавилт:**

Командын дагуу багийн бүх гишүүд эргэн нэгэн зэрэг хөдлөн багийн зохион байгуулалтанд шилжинэ.

**Хэрэглэгдэх газрууд:**

Энэхүү зохион байгуулалт нь урагшлах зохион байгуулалт юм.

- Үүрэгт газраа хүрэх явцад
- Аюул занал байхгүй болон багатай газраар урагшлах явцад
- Гудамж болон зам гарах явцад
- Үе шатлалтай зохион байгуулалтанд шилжиж болзошгүй тохиолдолд



Багийн нэгийн цуваанд жагсах

## 1.5 Багийн хоёр цуваат зохион байгуулалт

**Команд:** Хоёр цуваагаар жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2 дугаартай гишүүн команданд заагдсан зүгт урагшилна, бусад нь тэгш тоон /2, 4, 6, 8/ дугаартай гишүүдийн ард байраа эзэлнэ. 2 дугаартай гишүүний зүүн хажуугаар сондгой тоон /1, 3, 5, 7, 9/ дугаартай гишүүд ар араасаа цувран жагсана. Энэ нөхцөлд багийн ахлагч тэгш дугаартай гишүүдийн цувааны эхэнд, түүний туслах нь сондгой дугаартай гишүүдийн цувааны эцэст байраа эзэлнэ.

**Тавилт:**

Командын дараа багийн гишүүд бүгд эргэн нэгэн зэрэг хөдлөн сүүлийн гишүүнээс эхлэн сам маягаар зөрөлдөн багийн зохион байгуулалтанд шилжинэ.

**Хэрэглэгдэх газрууд:**

Энэхүү зохион байгуулалт нь зөвхөн урагшлах зохион байгуулалт бөгөөд аюул занал ойртсон үед хэрэглэгддэг.

- Үүрэгт газраа хүрэх явцад, давчуу гудамж болон замаар өнгөрөх үед
- Эгнээн болон жадан хэлбэрт зохион байгуулалтанд шилжиж болзошгүй тохиолдлуудад



*Багийн хоёрын цуваанд жагсах*

## 2. БҮЛГИЙН ТАКТИКИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дөрвөн баг зэрэгцэн жагссанаар бүлгийн зохион байгуулалтыг бий болгоно. Бүлгийн ахлагч нь ахлах офицер байна. Түүний туслах нь офицер байх ёстой. Бүлгийн ахлагч нь бүлгийг командлана. Бүх зохион байгуулалтын явцад бүлгийн ахлагчийн командын дараа

багийн ахлагч нар заагдсан цэгт ойртон зогсоно. 2 дугаартай гишүүн нь бүлгийн ахлагчийн өмнө гарч заагдсан газраас эхлэн зохион байгуулалтыг үүсгэж эхэлнэ. Бүлгийн зохион байгуулалтууд нь: гинжин, жадан, шатлалт, мөчир зохион байгуулалт гэж 4 хэсэгт хуваан үзэж болно. Зохион байгуулалт бүр нь олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын чанараас, хир олон хүнийг хамарсанаас, учруулж болох аюул заналаас шалтгаалан тактикийн зүйл ангиудыг бий болгодог.

## 2.1 Бүлгийн жагсаалын зохион байгуулалт


**Команд:** Бүлгийн жагсаалаар жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Бүлгийн ахлагчийн тушаал эсвэл командын дагуу 2 болон 3 дугаар багууд нэгэн зэрэг хөдөлнө. 2 дугаартай гишүүд нь зэрэгцэн, 2 баг баруун тийш жагсах зохион байгуулалтанд, 3 дугаар баг зүүн жагсах зохион байгуулалтанд шилжинэ. 1 дүгээр баг 2 дугаар багийн баруун талаар, 4 дүгээр баг 3 дугаар багийн зүүн талаар эгнээ болон байраа эзэлнэ. Багийн ахлагч нар нь 3, 4 дүгээр гишүүдийн ард талд, тэдний туслахууд 7, 8 дугаар гишүүдийн ард тус тус байрлана. Бүлгийн ахлагч нар нь 2 болон 3 дугаар багийн эгнээний дунд орчмын ар талд, түүний ард мэргэн бууч, 2 хажуу талд нь холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ард талд байрлана.

**Тавилт:**

Командын дагуу 1 ба 2 дугаар багууд баруун тийш, 3, 4 дүгээр багууд зүүн тийш эргэн нэгэн зэрэг хөдлөн сүүлчийнхээ гишүүдээс эхлэн задарч бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.



Бүлгийн жагсаалын зохион байгуулалт


## А. Бүлгийн 2 багийн дэмжлэгт эгнээн зохион байгуулалт

### Команд:

Бүлэг эгнээний зохион байгуулалтаар, 2 ба 3 дугаар баг ерөнхий дэмжлэгт жагсаад марш

### Хэрэгжүүлэлт:

2, 3 дугаар баг алхах цуваагаар зогсож, 1, 4 дүгээр баг зурагт үзүүлсэн хэлбэрт шилжинэ. Энэ нөхцөлд 1, 4 дүгээр багийн ахлагч нар багийнхаа ар талд, бүлгийн ахлагч нь хоёр багийн дунд, түүний ар талд мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана. 3, 4 дүгээр багууд эхэнд нь ахлагч нар нь байхаар алхах цуваанд орж; цувааны ард багийн ахлагч нарын туслахууд байрлана.



Бүлгийн, хоёр багийн дэмжлэгт, эгнээний зохион байгуулалт




## Б. Бүлгийн 2 багийн хажуугийн дэмжлэгт эгнээн зохион байгуулалт

**Команд:** Бүлэг эгнээний зохион байгуулалтаар, 2, 3 дугаар баг хажуугийн дэмжлэгт жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2, 3 дугаар баг байрандаа зогсож байх үед, 1, 4 дүгээр баг эгнээ бий болгоно. Энэхүү эгнээ бий болсоны дараа 2, 3 дугаар багийн ахлагч нар баруун жигүүр, зүүн жигүүр гэсэн команд өгнө. Зурагт үзүүлсэний дагуу 1, 4 дүгээр багийн ахлагч нар багийнхаа ар талд, 2, 3 дугаар багийн ахлагч нарын туслахууд тэдний ар талд, хажуу талын дэмжлэг болж буй 2, 3 дугаар багийн ахлагч нар багийнхаа сүүл хэсэгт байрлана. Бүлгийн ахлагч нь 1, 4 дүгээр багийн дунд орчимд, ар талд нь, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслагч нь эдгээр гурвын ар талд байрлана.



Бүлгийн 2 багийн хажуугийн дэмжлэгт эгнээн зохион байгуулалт

## В. Бүлгийн ойрын дэмжлэгт эгнээн зохион байгуулалт


**Команд:** Бүлэг ойрхон дэмжлэгт эгнээгээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Бүлгийн ахлагчийн тушаалаар эсвэл командаар 1, 4 дүгээр багууд нэгэн зэрэг урагшилж, 1 дүгээр баг баруун тийш, 4 дүгээр баг зүүн тийш эгнэх зохион байгуулалтанд шилжинэ. 2 дугаар баг 1 дүгээр багийн ар талд баруун тийш, 3 дугаар баг 4 дүгээр багийн ар талд зүүн тийш эгнэх зохион байгуулалтанд шилжин ойрын дэмжлэгийг бий болгоно. Бүх багуудын ахлагч нар 3, 4 дүгээр гишүүний дунд тушаа ард, багуудын ахлагч нарын туслахууд 7, 8 дугаар гишүүний дунд тушаа ард тус тус байрлана. Бүлгийн ахлагч нь яг гол дунд ар талдаа, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана. Команд өгөгдөх үед ар талын дэмжлэгийн баг, өмнө талын багийн гишүүдийн мөрийг нь тулж түшиг болно.

**Тавилт:**

Командын дагуу 1, 2 дугаар багууд баруун тийш, 3, 4 дүгээр багууд зүүн тийш эгнэн бүгд нэгэн зэрэг хөдлөн хамгийн сүүлчийн гишүүнээсээ эхлэн бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.




Бүлгийн ойрын дэмжлэгт эгнээн зохион байгуулалт

## Г. Бүлгийн нэг багийн дэмжлэгт эгнээн зохион байгуулалт

**Команд:** Бүлэг 3 дугаар багийн дэмжлэгт эгнээгээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2 дугаар баг нэгэн багийн эгнээгээр жагсана. 1 дугаар баг 2 дугаар багийн зүүн талд, 4 дүгээр баг 2 дугаар багийн баруун талд эгнээгээр жагсана. 3 дугаар багийн сондгой дугаартай гишүүдийн эгнээ зүүн талд, тэгш дугаартай гишүүдийн эгнээ баруун талд, 1, 2 болон 4 дүгээр багуудыг дэмжсэн байдлаар байрлана. 3 дугаар багийн ахлагч дэмжлэгийн баруун жигүүрт, түүний туслах нь зүүн жигүүрт байрлана. Бүлгийн ахлагч нь эгнээний яг голд, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч жагсан байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана /зурагт үзүүлсэнтэй адилаар/.



Бүлгийн нэг багийн дэмжлэгт эгнээн зохион байгуулалт


## 2.2 Бүлгийн шатлалт зохион байгуулалт

### А. Бүлгийн баруун тийш шатлалтай зохион байгуулалт

**Команд:** Бүлэг баруун тийш шатлалтай жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Бүлгийн ахлагчийн командын дагуу 4 дүгээр баг бүлгийн ахлагчийн заасан газар баруун тийш шатлалтай зохион байгуулалтанд шилжинэ. 3, 2 дугаар болон 1 дүгээр багууд ч мөн адил. Дарааллын дагуу команданд заагдсан зохион байгуулалтанд орж баруун тийш шатлалыг үргэлжлүүлнэ. Бүх бүлгийн ахлагч нар нь 3, 4 дүгээр гишүүдийн, туслахууд нь 7, 8 дугаар гишүүдийн ард байрлана. Бүлгийн ахлагч нь шатлалт зохион байгуулалтын дунд орчимд ард, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд нь байрлана.



*Бүлгийн баруун тийш шатлалтай зохион байгуулалт*

### Б. Бүлгийн зүүн тийш шатлалтай зохион байгуулалт

**Команд:** Бүлэг зүүн тийш шатлалтай жагсаад марш


**Хэрэгжүүлэлт:**

Бүлгийн ахлагчийн командын дагуу 1 дугаар баг, бүлгийн ахлагчийн заасан газар зүүн тийш шатлалтай зохион байгуулалтанд шилжинэ. 2, 3 болон 4 дүгээр багууд ч мөн адил, дарааллын дагуу командад заагдсан зохион байгуулалтанд орж зүүн тийш шатлалыг үргэлжлүүлнэ. Бүх бүлгийн ахлагч нар нь 3, 4

дүгээр гишүүдийн, туслахууд нь 7, 8 дугаар гишүүдийн ар талд байрлана. Бүлгийн ахлагч нар нь шатлалт зохион байгуулалтын дунд орчимд ард, түүний ард мэргэн бууч, хоёр талд нь холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана.

#### Тавилт:

Командын дагуу бүх багууд зүүн тийш эргэн бүгд нэгэн зэрэг хөдлөн хамгийн сүүлчийн гишүүдээс эхлэн бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.




*Бүлгийн зүүн тийш шатлалттай зохион байгуулалт*

#### В. Бүлгийн хоёр багийн хажуугийн дэмжлэгт зүүн тийш шатлалтай зохион байгуулалт

**Команд:** Бүлэг баруун зүүн тийш шатлалтайгаар, 3, 4 дүгээр багууд дэмжлэгт жагсаад марш

#### Хэрэгжүүлэлт:

3, 4 дүгээр баг ерөнхий дэмжлэгт, 1, 2 дугаар багууд зүүн тийш шатлалтай зохион байгуулалтанд шилжинэ. Баруун тийш шатлал үүсгэх гэж байгаа бол команд нь түүний дагуу өгөгдөнө. 3, 4 дүгээр багууд шатлал үүсгэж 1, 2 дугаар багууд нь хажуугийн дэмжлэг бий болгоно. Бүлгийн ахлагч болон түүний туслах нь зурагт үзүүлсэний дагуу хажууд нь байрлана.




Бүлгийн хоёр шатлалтай зохион байгуулалт

### Г. Бүлгийн хоёр багийн ерөнхий дэмжлэгт баруун тийш шатлалтай зохион байгуулалт

**Команд:** Бүлэг баруун талд 2 багийн дэмжлэгтэй, 2, 3 дугаар баг дэмжлэгт жагсаад марш

#### Хэрэгжүүлэлт:

1, 4 дүгээр багууд баруун тийш шатлал үүсгэж, 2, 3 дугаар багууд шатлалын ард алхах цуваанд 2 багийг дэмжих байдалтай зурагт үзүүлсэний дагуу зохион байгуулалтанд шилжинэ. 1, 4 дүгээр багуудын ахлагч нарууд болон тэдгээрийн туслахууд шатлал дахь багуудынхаа яг архан талд, 2, 3 дугаар багуудын ахлагч нар алхах цувааны өмнө, тэдний туслахууд нь багуудынхаа цувааны сүүлд



Бүлгийн хоёр багийн дэмжлэгт баруун тийш шатлалтай зохион байгуулалт

тус тус байрлана. Бүлгийн ахлагч нь шатлал дахь 1 дугаар багийн дунд орчимд, ар талд нь байрлана. Түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч нар нэг эгнээнд байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд нь байрлана.

#### **Д. Бүлгийн хоёр багийн хажуугийн дэмжлэг бүхий баруун эсвэл зүүн тийш шатлал бүхий зохион байгуулалт**

**Команд:** Бүлэг баруун зүүн тийш шатлалтай, 2, 3 дугаар багууд дэмжлэгт жагсаад марш

#### **Хэрэгжүүлэлт:**

Ойрын дэмжлэгтэйгээр зүүн эсвэл баруун тийш шатлал үүсгэж эхэлнэ. 2, 3 дугаар багууд нэгэн зэрэг хөдлөн 2 дугаар баг, 1 дугаар багийн, 3 дугаар баг 4 дүгээр багийн ар талд хоосон зай үлдээхгүйгээр шатлал дахь байраа эзэлнэ. Бүх бүлгийн ахлагч нар нь 3, 4 дүгээр гишүүдийн, туслахууд нь 7, 8 дугаар гишүүдийн ар талд байрлана. Бүлгийн ахлагч нь шатлалт зохион байгуулалтын дунд орчим ард, түүний ард мэргэн бууч, хоёр талд нь холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана.

#### **Тавилт:**

Командын дагуу бүх багууд нэгэн зэрэг хамгийн сүүлчийн гишүүдийн зогсож байсан зүг эргэн нэгэн зэрэг хөдөлж хамгийн сүүлчийн гишүүдээсээ эхлэн задарч бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.




*Бүлгийн хоёр багийн хажуугийн дэмжлэг бүхий баруун эсвэл зүүн тийш шатлал бүхий зохион байгуулалт*



### Е. Бүлгийн нэг багийн зүүн талын дэмжлэг бүхий зүүн тийш шатлалт зохион байгуулалт

**Команд:** Бүлэг нэг баг зүүн талд дэмжлэгтэйгээр, бусад багууд зүүн тийш шатлалтайгаар жагсаад марш



Бүлгийн хоёр багийн хажуугийн дэмжлэг бүхий баруун эсвэл зүүн тийш шатлал бүхий зохион байгуулалт

**Хэрэгжүүлэлт:**

4, 3, 2 дугаар багууд дэс дараалан зүүн талд шатлал үүсгэнэ. 1 дугаар баг 2 дугаар багийн сүүлийн гишүүнээс эхлэн зүүн талд дэмжлэг болон арагшаа жагссан зохион байгуулалтанд байрлалаа олно. Багуудын ахлагч нар болон туслахууд нь шатлал болон дэмжлэгийн архан талд байрлана. Дэмжлэг болж буй 1 дугаар багийн ахлагч нь баруун хажууд байрлана. Зурагт үзүүлсэний дагуу, бүлгийн ахлагч нар болон түүний ард нэг эгнээнд мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албна хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд нь байрлана. Бүлгийн ахлагч нь зүүн шатлалын дунд орчимд 3 дугаар багийн ар талд байрлана.

**2.3 Бүлгийн жадан зохион байгуулалт**

**Команд:** Бүлгийн жадан зохион байгуулалтаар жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Бүлгийн ахлагчийн командын дагуу 1 дугаар баг жадны баруун жигүүрт, 4 дүгээр баг зүүн жигүүрт байрлахаар нэгэн зэрэг хөдлөн жадан хэлбэрийг бий болгоно. 2 дугаар баг 1, 3 дугаар баг, 4 дүгээр багийн үзүүрээс эхлэн үргэлжлүүлэн жадан хэлбэрт орно. Бүх бүлгийн ахлагч нар нь 3, 4 дүгээр гишүүдийн туслахууд нь 7, 8 дугаар гишүүдийн ард байрлана. Бүлгийн ахлагч нь жадан зохион



*Бүлгийн жадан зохион байгуулалт*

байгуулалтын дунд орчимд ард, түүний ард мэргэн бууч, хоёр талд нь холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд байрлана.

**Тавилт:**

Командын дагуу бүх багууд нэгэн зэрэг 1 болон 2 дугаар багууд баруун тийш, 3 болон 4 дүгээр багууд зүүн тийш эргэн хамгийн сүүлчийн гишүүдээсээ эхлэн задарч бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.

**А. Бүлгийн нэг багийн дэмжлэгтэй жадан зохион байгуулалт**

**Команд:** Бүлэг жадан хэлбэрт шилжиж 2, 3 дугаар багууд дэмжлэг бий болгон жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**


2, 3 дугаар багууд алхах цуваанд орж 1, 4 дүгээр багууд зурагт үзүүлсэний дагуу жадан хэлбэрийг бий болгоно. Энэ үед 1, 4 дүгээр багийн ахлагч нар болон тэдгээрийн туслахууд нь багуудынхаа ард, 3, 4 дүгээр багийн ахлагч нар багуудын эхэнд, туслах нар нь багуудынхаа сүүлд байрлана. Бүлгийн ахлагч нь үүссэн жадан хэлбэрийн дунд, ар талд байрлаж мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч нар түүнтэй нэгэн эгнээнд байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ар талд дэмжлэгт хоёр багийн өмнө байрлана.

**Б. Бүлгийн хоёр багийн дэмжлэгт жадан зохион байгуулалт**


**Команд:** Бүлэг жадан хэлбэрт шилжиж 2, 3 дугаар багууд хажуугийн дэмжлэг бий болгон жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2, 3 дугаар багууд алхах цуваанд орж 1, 4 дүгээр багууд зурагт үзүүлсэний дагуу жадан хэлбэрийг бий болгон 2, 3 дугаар багийнхан өөрсдийн жигүүр лүү хөдлөн зурагт үзүүлсэн зохион байгуулалтыг бий болгоно. Багийн ахлагч нар болон тэдгээрийн туслахууд нь жадан хэлбэр дэх болон дэмжлэг дэх багуудынхаа дотор хэсэгт байрлана. Бүлгийн ахлагч нь үүссэн хэлбэрийн яг дунд нь, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч нар нэгэн эгнээнд байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээрийн ар талд байрлана.



Бүлгийн нэг багийн дэмжлэгтэй жадан зохион байгуулалт



Бүлгийн хоёр багийн дэмжлэгтэй жадан зохион байгуулалт

## В. Бүлгийн хоёр багийн ойрын дэмжлэгтэй жадан зохион байгуулалт


**Команд:** Бүлэг ойрын дэмжлэгт жадан хэлбэрт жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**


1, 4 дүгээр багууд жадан зохион байгуулалтыг бий болгоно. 2 дугаар баг, 1, 3 дугаар баг 4 дүгээр багийн архан талд хоосон зай үлдээхгүйгээр жадан хэлбэр дэх байраа эзэлнэ. Бүх бүлгийн ахлагч нар нь 3, 4 дүгээр гишүүдийн, туслахууд нь 7, 8 дугаар гишүүдийн ар талд байрлана. Бүлгийн ахлагч нь жадан зохион байгуулалтын дунд орчим ард, түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч байрлана. Бүлгийн ахлагчийн туслах нь эдгээр гурвын ард байрлана.

**Тавилт:**

Командын дагуу 1 болон 2 дугаар багууд баруун тийш, 3 болон 4 дүгээр багууд зүүн тийш эргэн нэгэн зэрэг хамгийн сүүлийн гишүүдээсээ эхлэн задарч бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.



*Бүлгийн хоёр багийн ойрын дэмжлэгтэй жадан зохион байгуулалт*



Бүлгийн нэг багийн ерөнхий дэмжлэгтэй жадан зохион байгуулалт

## Г. Бүлгийн нэг багийн ерөнхий дэмжлэгтэй жадан зохион байгуулалт

**Команд:** Бүлэг жадан хэлбэрт шилжин 3 дугаар баг дэмжлэгт жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

2 дугаар баг тарсан нэгэн жадан хэлбэрийг бий болгоно. 2 дугаар багийн дагуу 1 дүгээр баг зүүн тийш, 4 дүгээр баг баруун тийш шатлал үүсгэнэ. 3 дугаар баг алхах цуваанд үлдэнэ. Зурагт үзүүлсэн хэлбэрийг бий болгоно. Энэ үед жадан хэлбэрийг үүсгэж буй 1, 2, 4 дүгээр багуудын ахлагч нар болон тэдний туслахууд жадан хэлбэрийн дотор, багуудынхаа эхэнд байрлана. Дэмжлэг үзүүлж буй 3 дугаар багийн ахлагч нь багийнхаа эхэнд, түүний туслах нь багийнхаа сүүлд байрлана. Бүлгийн ахлагч нь жадан зохион байгуулалтын дунд байрлана. Түүний ард мэргэн бууч, холбоочин болон автомат буутай албан хаагч нар байрлана. Бүлгийн ахлагчийн туслагч нь эдгээр гурвын ард байрлана.

*/Зураг өмнөх хуудсанд/*

## 2.4 Бүлгийн цуваагаар жагсах зохион байгуулалт

Бүлгийн цуваат зохион байгуулалтанд нь зөвхөн урагшлах зохион байгуулалт бөгөөд бүлгийн гишүүдийн багийн жагсаалд болон баг дахь дугаарынхаа дагуу нэг нэгнийхээ ард жагсах хэлбэр юм. Энэхүү зохион байгуулалт нь үүрэгт газарт урагшлах явцад, гудамж болон зам гаргах үед, зарим тохиолдолд шатлалт зохион байгуулалтанд шилжих үед, гинжин зохион байгуулалт үүсгэх үед, анчингийн бүлэг болон жадан хэлбэрт шилжих үед хэрэглэгддэг. Бүлгийн цуваат зохион байгуулалт нь 2 хэлбэрээр хэрэгждэг.

### А. Бүлгийн нэг цуваат зохион байгуулалт

**Команд:** Бүлэг нэг цуваанд жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

1 дугаар баг, ахлагч нь хамгийн эхэнд байрлахаар, дарааллаараа бүх багууд ахлагч болон туслахуудын хамт ар араасаа өмнөхүүдтэй нэгэн гарын зай үлдээх хэмжээтэйгээр цуван жагсана.



## **Б. Бүлгийн хоёр цуваат зохион байгуулалт**

**Команд:** Бүлэг хоёр цуваанд жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

1 дугаар багийн ахлагч нь байраа эзэлнэ. Багийн тэгш тоон дугаартай гишүүд түүний араас цувран жагсана. Зүүн хажууд нь 3 дугаартай гишүүнээс эхлэн сондгой тоон дугаартай гишүүд ар араасаа цувран жагсана. Багийн ахлагчийн туслах нь сондгой дугаартай гишүүдийн цувааны эцэст байрлана. 2, 3, 4 дүгээр багийнхан ч мөн адил байдлаар цувран жагсана.

## **В. Бүлгийн хайрцган зохион байгуулалт**

**Команд:** Бүлэг хайрцган хэлбэрээр жагсаад марш

**Хэрэгжүүлэлт:**

Нэг цуваат 4 дүгээр багуудаас 1 дугаар баг урагш хөдлөн хамгаалах гэж байгаа зүйлийн /машин гэх мэт/ өмнө нь эгнээ болон жагсана. 2 дугаар баг /жишээ нь машины/ баруун өмнө нь 1 дугаар багийн 10 дугаартай гишүүний ар талаас эхлэн нэгийн цуваанд орон жагсана. 3 дугаар баг машины ар талд нэг эгнээ болон жагсана. 4 дүгээр баг машины зүүн урдаас 2 дугаар багийн 2 дугаартай гишүүнээс ар талаасаа нэгийн цуваанд орон жагсаж хайрцаг бий болгоно. Багийн ахлагч нар нь өөрсдийн багийнхаа 5 дугаартай гишүүдийн хажуу талд хайрцагны дотор талд нь байрлана.

**Тавилт:**

Командын дагуу бүх багууд хамгийн сүүлчийн гишүүдийнхээ зүг эргэн нэгэн зэрэг хөдлөн хамгийн сүүлчийн гишүүдээсээ эхлэн задарч бүлгийн зохион байгуулалтанд шилжинэ.


### 3. САЛААНЫ ТАКТИКИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТУУД

Хэрэглэгдэх бүлгийн тактикуудын тусламжтайгаар хорьж үл дийлдэх олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг намжаахын тулд илүү их хүч хэрэг болсон үед салааны зохион байгуулалттайгаар хэрэг явдалд ханддаг. Салааны ахлагчийн өгсөн командын дагуу 3 бүлгээс бүрдэх салаа тактикийн зохион байгуулалтанд шилжинэ.

Эдгээр тактикийн зохион байгуулалтууд нь:

- 3.1 Нэг бүлгийн ойрын дэмжлэгтэй салааны зохион байгуулалт
- 3.2 Бүлгийн нэгдсэн эгнээт зохион байгуулалт
- 3.3 Нэг бүлгийн хажуугийн, нэг бүлгийн ерөнхий дэмжлэгтэй салааны зохион байгуулалт
- 3.4 Баруун зүүн тийш нэг бүлэг хажуугийн дэмжлэгтэй салааны шатлалт зохион байгуулалт
- 3.5 Нэг бүлгийн ерөнхий дэмжлэгтэй салааны шатлалт зохион байгуулалт
- 3.6 Хоёр бүлгийн ерөнхий дэмжлэгтэй салааны жадан зохион байгуулалт
- 3.7 Нэг бүлгийн хажуугийн дэмжлэгтэй салааны нэгдсэн жадан зохион байгуулалт
- 3.8 Нэг бүлгийн хажуугийн дэмжлэгтэй салааны жадан зохион байгуулалт

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ



ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН  
АНХНЫ ТУСЛАМЖ

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

### ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

#### ЦУС АЛДАЛТЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

Шархнаас гадагш цус гарахыг цус алдалт гэнэ. Их хэмжээгээр цус алдах нь амь насанд аюултай. Цус алдалтыг дотор нь:

1. **Хялгасан судаснаас цус алдах:** Энэ үед цус шүүрч алдах учир шарханд иод түрхэж хэд хэдэн давхар маарль тавьж бооно.
2. **Венийн судаснаас цус алдах:** Хар хүрэн өнгөтэй, тасралтгүй урсах маягаар удаан гоожих шархнаас гарна. Маш хүчтэй гарах тул аюултай.
3. **Артерийн судаснаас цус алдах:** Тод улаан өнгөтэй, маш хүчтэй олгойдон гарна. Томоохон судас гэмтсэнээс цус алдана.
4. **Дотуур цус алдах:** Элэг, бөөр, дэлүү гэмтэхэд артери, венийн, хялгасан судасны цус алдалт холилдон гардаг тул оношлоход төвөгтэй.


#### Цус тогтоох аргууд

Цус алдалт нь ялангуяа томоохон судаснаас цус алдах үед артерийн судасны гадна талаас дарж болох бүх цэг, газруудыг сайн мэддэг байх хэрэгтэй. Энэ хооронд дараах арга хэмжээг төлөвлөнө.

Зураг 1

#### Артерийн судасны цэгүүд

1. Чамархай
2. Эрүүний гадна
3. Гүрээний
4. Эгэмний
5. Бугалганы
6. Шууны
7. Бугуйны
8. Суганы
9. Хэвлийн гол судас
10. Гуяны
11. Тахимны




*Артерийн судсыг хуруугаар дарж цус тогтоох*

1. Гүрээний
2. Эгэмний
3. Бугалганы
4. Гуяны

*Мөчүүдийг нугалж цус тогтоох*

1. Бугалганаас цус алдахад бугалгаар их биетэй шахаж боох
2. Шуунаас цус алдахад тохойн үеэр нугалах
3. Гуянаас цус алдахад түнхний үеэр нугалах
4. Шилбэ, тохойноос цус алдахад өвдөгний үеэр нугалах
  - Түр зуур цус тогтоохын тулд үеэр нугалж нугалах хэсэгт хөвөн даавуугаар жийрэг тавьж бооно.
  - Том артерийн судас гэмтсэн үед мөчинд чангалуур тавьж цус тогтооно. Үүнд: Бүс, алчуур, тэлээ зэргийг ашиглана.
  - Дээд мөчний артерийн судасны цус алдалтын үед чангалуураа бугалганы дээд хэсэгт, доод мөчний артерийн судасны цус алдалтын үед гуяны дунд хэсэгт тавина.
  - Чангалуур тавих мөчийг өргөж мөчийг тойруулан хэд хэдэн удаа ороож төгсгөлийг нь сайтар бэхэлнэ. Чангалуурыг тавьсан цаг хугацааг тодорхой бичнэ. 1-1.5 цагаас илүү тавихгүй.

Зураг 2



Цус тогтоох чангалуур тавих байрлал

1. Мөр бугалганд
2. Шууд тохойноос
3. Гуянаас
4. Шилбэ, тавхайнаас



Зураг 3

### Зүрх зогсох үед үзүүлэх анхны тусламж

Зүрх зогсох нь үхлийн нэг шалтгаан юм. Хэрэв хохирогчийн зүрх цохилохгүй үед:


- Гүрээний артер болон шуунд судасны цохилт алга болно
- Ухаангүй болох, зүрх зогссоны дараа 4-5 секундын дотор хохирогч гадаад орчинтой харьцахгүй, цочролд хариу өгөхгүй гөлгөр байдалд орно.
- Хүүхэн хараа гэрлийн урвалд хариу өгөхгүй, дээд зовхийг өргөж гэрэл тусгахад хүүхэн хараа өргөсөж нарийсахгүй болдог.
- Амьсгал зогсох. Цээж болон хэвлий амьсгалд оролцохгүй болох нь харагдана.
- Нүүр хөхөрч үнсэн саарал болно. Энэ үед 1-рт амьсгалын замын салст гадны биетийг чөлөөлнө. Хохирогчийн толгойг гэдрэг болгон амны хөндийг үзэж гадны биетийг цэвэрлэнэ. 2 -рт уушгинд зохиомол амьсгал хийнэ. Хохирогчийг хатуу зүйл дээр хэвтүүлж хэвлий, цээж барьсан хувцасыг чөлөөлнө.

**Амнаас аманд амьсгал өгөх:** Хохирогчийн толгойг гэдийлгэн амны хөндийг нээн аман дээр алчуур, салфетка тавьж туслагч гүнзгий амьсгал авсны дараа хохирогчийн ам руу хүчтэй үлээж өгнө. Энэ үед хамрыг чимхэсэн байна. Нэгэн зэрэг цээжний хөдөлгөөнийг хянана. Үлээхэд цээж өргөгдөж, амьсгал гаргахад цээж намсана.

**Амнаас хамарт амьсгал өгөх:** Нэг гараа хохирогчийн духанд байрлуулан толгойг гэдийлгэн нөгөө гараараа эрүүн доороос өргөн амыг нь хамхина. Амьсгалыг хамрын нүхээр хийж амьсгал гаргах үед амыг нь хагас ангайлгах хэрэгтэй. Зохиомол амьсгалыг нэг минутад 16-18 удаа давтана.

**Зүрхний шууд бус иллэг:** Хохирогчийг хатуу газар хэвтүүлнэ. Тусламж үзүүлэгч хохирогчийн хажуу талд байрлаж өвчүүний бүдэрхийнээс доош 2 см зайд 2 гарын алгыг зөрүүлэн тавина. Гарыг тохойны үеэр нугалахгүйгээр өвчүүн дээрээс нугалмын их бие рүү чиглүүлэн 4-5 см гүн хүчтэй дарна. Гарын хүчээр бус биеийн жингээр дарж өгнө. 1 минутад 60 удаа дарна. Зүрхний иллэгийг зохиомол амьсгалтай хослуулан хийвэл үр дүнтэй. Энэ нь нэг удаа ам руу нь амьсгал өгч 4 удаа цээжинд дарна. 2 хүн тусламж үзүүлбэл нэг нь зүрхэнд иллэг хийж нөгөө нь амьсгал өгч болно. Эдгээр аргууд үр дүнтэй болбол хохирогчийн нүүрний өнгө өөрчлөгдөж гүрээний артерийн судасны лугшилт тодорхойлогдон хүүхэн хараа нарийсна.

Зураг 4



Хиймэл амьсгал болон зүрхэнд шууд бус иллэг хийх арга

**Амьд хүний шинж**

1. Зүрхний цохилт: Цээжний зүүн хөхний орчим чих эсвэл гараа тавьж тодорхойлно.
2. Судасны цохилт: Гүрээний артер, тохой, цавь, шуунд үзнэ.
3. Амьсгал: Хэвлий, цээж амьсгалд оролцоно. Мөн хамарт утас, цаас барьж үзэж болно.
4. Хүүхэн хараа гэрэл мэдрэх: Нүдийг гараараа нэг зэрэг дарж байгаад гэнэт гараа хурдан авахад хүүхэн хараа агшин зуур мэдэгдэнэ.


**Үхсэн хүний шинж**

1. Нүдний бүрхүүл бүдгэрч хатсан байна.
2. Хүүхэн хараа нарийсаж хөшнө.
3. Бие хөрч үхлийн толбо гарч ирнэ. Энэ нь нуруугаар тавьсан үед дал, өгзөгөнд, хэвлийгээр тавьсан үед нүүр, хүзүү, цээж, гэдсэнд толбо гарна.

**Шарханд үзүүлэх анхны тусламж**

Шарх гэдэг нь гадны хүчний үйлчлэлээр арьс, салст, бүрхэвч, эд эрхтэний бүрэн бүтэн байдал алдагдахыг хэлнэ. Шарх нь өнгөц, гүн, хөндийт эрхтэнд нэвтэрсэн гэж байна. Шархтсан үед өвдөлд ба цус алдалтаар анхны шинж тэмдэг илэрнэ. Цус алдаж буй шарханд хөвөн, даавуу, маарль давхарлан даралттай боолт хийнэ. Хүчтэй цус алдвал чангалуур тавина. Шарханд нэвтэрсэн гадны биет /шил, мод, төмөр, хутга/ зэргийг ямар ч үед авч болохгүй. Хохирогчийг яаралтай, дамнуургаар ойролцоо эмнэлэгт хүргэнэ.

Зураг 5



Гадны биет болон хутга зосгдсон үед үзүүлэх анхны тусламж



## Хэвлийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж


### Хэвлийн битүү гэмтэл:

Энэ үед арьсны гадаргуу бүтэн байх ба мохоо зүйлд цохиулах, өшиглүүлэх зэрэгт үүснэ. Урд талаас хүчтэй цохиход гэдэс, ходоод, элэг гэмтэнэ. Хажуугаас цохиход элэг, дэлүү бөөр гэмтэнэ.

### Хэвлийн ил гэмтэл:

Энэ үед шархаар гэдэсний гогцоо, сэмж, гэдсэн доторхи шингэн ялгарч ямар нэгэн эрхтэн гэмтсэнийг тодруулна. Анхны тусламжийг хохирогчийг аятай байдалд байрлуулан шархаар ил гарсан дотор эрхтэнийг цэвэр алчуур, даавуугаар битүүлж бооно. Шархаар ил гарсан дотор эрхтнийг хэвлийд чихэж огт болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Зураг 6



*Ил гарсан дотор эрхтнийг хэвлийд чихэжгүй анхны тусламж үзүүлэх арга*

## Цээжний гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж

### Цээжний битүү гэмтэл:

Цээж дарагдах, доргих, хананы бэртэл нь цээжээр хатуу зүйл дээр унах, цохиулах, өндрөөс унах үед үүснэ. Энэ үед хохирогчийг тайвшруулж хагас суугаа байдалд цээжийг өндөрлөн хувцасны зах, бүсийг суллана. Хавдаж хөхөрсөн хэсэгт хүйтэн жин тавина.

**Цээжний ил гэмтэл:**

Дотор нь нэвтэрсэн, нэвтрээгүй гэж хуваана. Нэвтрээгүй гэмтлийн үед плеврийн хөндий бүтэн, арьс, булчин, судасны гэмтэл нь шархны гүнээс хамаарна. Энэ үед шарханд цэвэр боолт хийж зөөвөрлөнө. Нэвтэрсэн гэмтлийн үед агаар плеврийн хөндийд орж уушиг гэмтэж, цустай ханиалгана. Энэ үед цээжний хөндийд агаар оруулахгүйгээр сайтар боож эмнэлэгт яаралтай хүргэнэ.

**Нүүр хүзүүний гэмтэлд үзүүлэх анхны тусламж**

Нүүрэнд бэртэл авахад зөөлөн эдэд цус харвалт үүсч хөхөрч хавдана. Хүйтэн жин тавьж зөөлөн боолт хийнэ. Өнгөц шарх, шалбархайг иодын уусмалаар цэвэрлэж шархны лентээр шархны захыг ойртуулах маягтай нааж бооно. Яснуудаас голчлон хамрын яс хугардаг. Цус алдсан үед толгойг өндийлгөн хүйтэн жин тавьж цус тогтохгүй бол 3% - ийн устөрөгчийн хэт исэл бүхий чихээсийг хамрын хөндийд хийж амаар байнга шүлс, цусаа гаргаж байхыг зөвлөнө. Нүдний гэмтлийн үед цэвэр боолт хийж алчуураар бооно. Нүдийг угааж болохгүй. Химийн түлэгдлийн үед усаар угаана. Хүзүү гэмтэх үед залгиур, төвөнхи, бамбай булчирхай, мөгөөрсөн хоолой болон мэдрэлийн том судас, судал ихтэй тул анхны тусламжийг зөв хурдан үзүүлж эмнэлэгт яаралтай хүргэнэ.

**Үений мултралт, ясны хугаралтад үзүүлэх анхны тусламж**

Үений мултралт нь гэмтлийн улмаас үе үүсгэж буй яснуудын байрлал өөрчлөгдөхийг үе мултралт гэнэ.

**Илрэх шинж тэмдэг**

1. Үений ерөнхий хэлбэр нь эрүүл талтай харьцуулахад өөрчлөгдсөн байна.
2. Мултарсан үений хөдөлгөөн эрс хязгаарлагдана. Үеийг хөдөлгөөд тавихад буцаж нэг байрлалдаа орох пүршний шинж илэрнэ.
3. Өвдөлтөөс болж мултралттай мөчийг аргагүйдсэн байдалтай байрлуулна.
4. Үе орчимд тэмтрэхэд чөмөгний толгой тусдаа, тогоо нь хоосон тэмтрэгдэнэ.
5. Мултарсан мөч богиносох, уртсах мэт болно. Энэ нь дээш мултарвал богиносож, доош мултарвал уртасна.

6. Мөчний чиг өөрчлөгдөнө. Мултарсан талын мөчний үзүүр нь хэвэндээ биш гадуур чиглэлтэй болно. Үений мултралыг рентген зураг авч, мэдээ алдуулалтаар засч оруулах тул яаралтай эмнэлэгт хүргэж өгнө.

### Ясны хугаралт


Гадны хүчний үйлчлэлээр ясны бүрэн бүтэн байдал алдагдаж орчны зөөлөн эд гэмтэхийг хугаралт гэнэ. Илрэх шинж тэмдэг.

1. Өвдөлт маш их байна.
2. Ясны хугаралттай хэсэгт хаван хавдартай байна.
3. Хугарсан хэсэг эмгэг хөдөлгөөн хийнэ.
4. Мөн хугарсан яс хоорондоо хавирах чимээ гарна.
5. Хугарсан эрхтний үйл ажиллагаа алдагдана.
6. Тулгуур алдагдана.

Эдгээр гэмтлүүдийн үед өөрсдөө хугаралт, мултралтыг зассанаар мэдрэлийн судас судал гэмтэх аюултай байдаг тул эмнэлгийн байгууллагад яаралтай үзүүлнэ.

Ясны хугарлын үед хохирогчид юуны түрүүнд өвчин намдаах эм өгч гарын доорхи материалаар хөдөлгөөнгүй чиг тавина. Мөн гурвалжин хэлбэрийн алчуур ашиглан боолт хийж болно. Гарын яс хугарсан үед биед нь сойж бооно.

Зураг 7




Гурвалжин алчуур ашиглаж сойж боох арга


Чиг тавихад анхаарах гол зүйл: Хугарсан ясны хоёр талын үеийг хугарсан ясны хамт хөдөлгөөнгүйгээр барьж боох явдал юм. Чигийг хугарсан ясны гадна, дотор хоёр талд нь тавина. Чигний гадуур зөөлөн даавуугаар давхар бооно. Хөл гарын хурууг ил гаргана. Хуруу хөрч

хөхөрвөл чигийг суллаж бооно. Жишээ нь: Шилбэ яс хугарсан бол өвдөг хөлийн тавхайг оролцуулан чиг барьж боогоод зөөвөрлөх бөгөөд чиг тавих материалгүй үед эрүүл хөлтэй нь хамт боогоод дамнуураар зөөвөрлөнө.

Зураг 8



Доод мөчний яс хугарлын үед чиг барьж боох арга



## НОМ ЗҮЙ

## МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХИ ЗОХИОЛУУД

- |     |                                     |  |
|-----|-------------------------------------|--|
| 1.  | МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ           |  |
| 2.  | ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ | 1993   |
| 3.  | ЦЕГ -ЫН 75 ТООТ ТУШААЛ              | 1994   |
| 4.  | ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ                     | 2002   |
| 5.  | МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ         | 2002   |
| 6.  | Л. ПҮРЭВХҮҮ                         | КИОКУШИН КАРАТЭ 1991, УБ                     |
| 7.  | Г. ЛХАГВАСҮРЭН                      | БИЕ БЯЛДРЫН ХҮМҮҮЖЛИЙН<br>ОНОЛ АРГА ЗҮЙ 1995 |
| 8.  | Г. ЛХАГВАСҮРЭН                      | СПОРТЫН ДАСГАЛЖУУЛАЛТЫН<br>ҮНДЭС 2003        |
| 9.  | Г. ЭРДЭНЭ                           | БАРИЛДАХ УР 1992                             |
| 10. | Л. ТОД, В. ЧУЛУУНБАТ                | ХАЛЗ ТУЛААНЫ УРЛАГ 1992                      |
| 11. | Б. БАТАА                            | БАЙЛДААНЫ САМБО 1988                         |
| 12. | Д. ОТГОНБАЯР                        | МОНГОЛ ЗОО 1998                              |

## ГАДААД ХЭЛ ДЭЭРХИ ЗОХИОЛУУД

- |     |   |                                  |
|-----|---|----------------------------------|
| 1.  | КУК Д. Ч.   | СИЛА КАРАТЭ 1992                 |
| 2.  | BASRI OZDEMIR Dr.   | YAKIN SAVUNMA TEKNIKLERI<br>2002 |
| 3.  | HIDEYUKI ASHINARA   | MORE FIGHTING KARATE 2000        |
| 4.  | BASRI OZDEMIR Dr.   | POLIS TAKTIKLERI 2001            |
| 5.  | МОРГУНОВ В. Н.  | АЙКИДО 1991                      |
| 6.  | ДАВИД ЛЬВОВИЧ РУДМАН  | САМБО 1979                       |
| 7.  | МИХАЛ ВАХУМ   | ДЗЮДО 1983                       |
| 8.  | FRANTISHEK MISC   | KARATE 1982                      |
| 9.  | ЦС ДИНАМО   | САМБО 1970                       |
| 10. | РУДМАН Д.   | СТО СТО БАРЬБЫ САМБО             |
| 11. | СЕЛИВЕРСТОВ С. А.   | САМБО 1997                       |
| 12. | МИХАЙЛОВА И.  | УМЕЙ СЕБЯ ЗАЩИТИТЬ 1992          |
| 13. | ИВАНОВ-КАТАНСКИЙ С. А.  | ВЫСШАЯ ТЕХНИКА КАРАТЕ<br>2001    |
| 15. | АКОПОВ А. А., ВАШУРИН К. М.   |                                  |
|     | БОЕВЫЕ ПРИЕМЫ САМБО. УЧЕБНО-МЕТОДИЧЕСКОЕ<br>ПОСОБИЕ ДЛЯ СПЕЦИАЛЬНЫХ СРЕДНИХ ЗАВЕДЕНИЙ<br>МВД СССР | 1970                             |
| 14. | НАСТАВЛЕНИЕ ПО ПОДГОТОВКЕ К РУКОПАШНОМУ БОЮ   |                                  |



## Батсайханы БАТЖАВ

*Цагдаагийн Академийн Албаны ба Авто бэлтгэлийн Тэнхимийн Бие хамгаалах тактикийн багш, Цагдаагийн хошууч*

Эрх зүйч, криминалистикийн шинжээч мэргэжилтэй.

- \*1990 -1993 онд Дорнод аймгийн Цагдан сэргийлэх хэлтэст сэргийлэгч, цагдаа
- \*1993-2001 онд Дорнод аймгийн Цагдаагийн газарт Криминалистикийн шинжээч
- \*2001 оноос хойш Цагдаагийн Академид багшаар ажиллаж байна.
  
- \*1997 онд Удирдлагын Институт
- \*1992 -1993 онд Цагдаагийн Ерөнхий Газрын Криминалистикийн Шинжилгээний төв
- \*2004 онд Цагдаагийн Академийг тус тус дүүргэсэн.
  
- \*2001 онд Бие хамгаалах тактик -1 гарын авлага /Зэвсэггүйгээр тулалдах/
- \*2003 онд Бие хамгаалах тактик -2 гарын авлага
- \*Галт зэвсэг, резин бороохойг хэрэглэх тактик/ номуудыг бичиж хэвлүүлэн олны хүртээл болгосон.
  
- \*"Цагдаагийн мэргэжил олгох сургалтанд бие хамгаалах тактик хичээлийг заах арга зүйн зарим асуудал" сэдвээр хоёр удаа эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан.

